



## Гүйцэтгэл-Нийцлийн аудитын тайлан

2024 оны 9 дүгээр сар

**АУДИТЫН СЭДЭВ: МОНГОЛ УЛСЫН 2025  
ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН  
АУДИТЫН ДҮГНЭЛТ**



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

「Аудитын тайланг баталгаажуулах тухай」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням), олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол) нарт тус тус даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг, Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Л. Гантөмөр), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг), Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд) нарт тус тус даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг Санхүү, нийцлийн аудитын газрын Аудитын менежер (Л.Мөнхцацрал)-т үүрэг болгосугай.

  
Д.ЗАГДЖАВ



## АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл .....	2
<b>НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>6</b>
Макро эдийн засгийн 2025 оны төлөв байдал .....	6
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОЛОН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙГЭЭС ТҮҮНД ЧИГЛЭСЭН ЭСЭХИЙГ ДҮГНЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА</b> .....	<b>10</b>
Үндэсний аюулегүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна .....	11
<b>ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА</b> .....	<b>13</b>
Төсвийн хүрээний мэдээгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг байдал давтагдаж байна .....	14
<b>ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ГОЛЛОХ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН БУУРАЛТААС ШАЛТГААЛЖ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА</b> .....	<b>16</b>
<b>ТАВ. ЗАСГИЙН ГАЗАР УРСГАЛ ЗАРДЛЫГ ӨМНӨХ ОНООС 3,565.6 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР ТӨСВИЙН ХЯЗГААРЫГ ХЭТРҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА</b> .....	<b>19</b>
<b>ЗУРГАА. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ТОМООХОН ТӨСЛҮҮДЭД ЧИГЛҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА</b> .....	<b>26</b>
Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, эрэмбэд суурилан төлөвлөх аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байна .....	28
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд багц байдлаар тусгасан төсөл, арга хэмжээний байршил, төсөвт өртгийн задаргааг тусгайлан батлах шаардлагатай байна .....	29
Тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг ашиглалтын хугацаа, элэгдлийн зардалтай уялдуулан урсгал зардалд төлөвлөж санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай байна .....	30
Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байна .....	31
Төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөх шаардлагатай байна .....	31
Өмнөх аудитаар ТЕЗ нарт өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжилт хангалтгүй байна .....	32
<b>ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙГ НЭРЛЭСЭН ДҮНГЭЭР 40,493.0 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР ТООЦСОН НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙНА</b> .....	<b>33</b>
<b>НАЙМ. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙНА</b> .....	<b>35</b>
<b>ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 69.0 ХУВЬ БАЙНА</b> .....	<b>36</b>
<b>ДҮГНЭЛТ:</b> .....	<b>37</b>
<b>ЗӨВЛӨМЖ:</b> .....	<b>39</b>
<b>Хавсралтууд:</b> .....	<b>41</b>



<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2023 оны Аудитын сэдэв батлах 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.</p>
<b>Аудитын зорилго</b>	<p>Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх доорх асуултад хариулт өгөхөд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➢ Төсвийн төсөл нь улсын тогтвортой хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;</li><li>➢ Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;</li><li>➢ Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Төсвийн урсгал зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;</li><li>➢ Төсвийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөх өрийн хэмжээг тогтоохдоо тусгай шаардлага хууль тогтоомжид нийцүүлж боловсруулсан эсэх;</li><li>➢ Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөсөн эсэх.</li></ul>
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	<p>Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.</p> <p>Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.</p> <p>Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.</p>



**Аудитын хамарсан  
хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, Үндэсний баялгийн сан/-ийн 2025 оны төсвийн төсөл, 2022, 2023, 2024 оны батлагдсан төсөв /тодотгосон/, төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.

Мөн аудитад Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.

**Талуудын хүлээх  
үүрэг, хариуцлага**

Засгийн газар улсын төсөв, орон нутгийн төсөв /суурь орлого, зарлага/ Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсвийн төслийг танилцуулгын хамт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5-т заасны дагуу жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2, 23.1.3-т заасны дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж, Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх дүгнэлтийг Улсын Их Хуралд жил бүрийн 9 дүгээр сарын 25-нд хүргүүлж, нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

**Аудитын бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Л.Мөнхцацрал хэрэгжүүлж, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, Ш.Наран, Л.Нямтөмөр, Чанарын удирдлагын газрын аудитор Ж.Мөнхбилгүүн, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Г.Оюунтөгөлдөр, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор Д.Нямжаргал, Б.Идэрбалжинням, Стратеги, төлөвлөлтийн газрын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал хариуцсан шинжээч Б.Мөнхтуяа, Стратеги, төлөвлөлтийн газрын судалгаа хариуцсан шинжээч Н.Цэрэнбалжир, Эрсдэлийн удирдлагын газрын аудитор М.Доржханд нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	АЖ АХУЙН НЭГЖ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
АМНАТ	АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
БНСУ	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
БНХАУ	БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС
БОУАӨС	БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
ГЕГ	ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГЗТ	ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖ
ГХС	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ЗТС	ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
МУЕ	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
МУЗГ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
НДС	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН
ОНХС	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
ОХУ	ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС
ОУВС	ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН
ӨҮЦ	ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭ
ТАЗ	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
ТАХ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
ТЕГ	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТТБЗ	ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ
ТӨААТҮГ	ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ТӨҮГ	ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
УТХО	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ҮБС	ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН
ҮОМШӨ	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН
ХББОСС	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД
ХБГ	ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ
ХЗДХС	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
ХК	ХУВЬЦААТ КОМПАНИ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ЭЗХАХБ	ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА
ЭЗХС	ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН САЙД
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл	7
Хүснэгт 2	Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, /тэрбум төгрөгөөр/	9
Хүснэгт 3	Монгол Улсын хөгжлийн бодлого болон төсөв хоорондын уялдаа /тэрбум төгрөг/	11
Хүснэгт 4	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал	13
Хүснэгт 5	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан бусад шалгуурыг хангасан байдал	14
Хүснэгт 6	Төсвийн хүрээний мэдэгдлийн таамаглал болон хууль хоорондын зөрүү	15
Хүснэгт 7	Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ	17
Хүснэгт 8	Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн харьцуулалт	17
Хүснэгт 9	Төсвийн шатлалаар /тэрбум төгрөг/	21
Хүснэгт 10	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсөв /тэрбум төгрөг/	23
Хүснэгт 11	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөв /тэрбум төгрөг/	24
Хүснэгт 12	Эрүүл мэндийн даатгалын сан 2025 оны зарлага-тусламж, үйлчилгээний төрлөөр /тэрбум төгрөг/	25
Хүснэгт 13	Хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөгөө /тэрбум төгрөг/	26
Хүснэгт 14	Концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх ТАХ /тэрбум төгрөг/	27
Хүснэгт 15	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн уялдаа	28
Хүснэгт 16	ТЕЗ-аас төсвийн төсөлд хүргүүлсэн болон тусгагдсан ТАХ-ний санал	28
Хүснэгт 17	Засгийн газрын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/	33
Хүснэгт 18	Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр /тэрбум төгрөг/	35
Хүснэгт 19	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/	35
Хүснэгт 20	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн мэдээ	36

## Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын харьцуулалт /хувиар/	16
Дүрслэл 2	Нийт зарлага /тэрбум төгрөг/	20
Дүрслэл 3	Төрийн албан хаагчийн тоо /албан тушаалын ангилал/	22
Дүрслэл 4	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгагдаагүй шилжих төсөл, арга хэмжээ	29
Дүрслэл 5	Засгийн газрын өрийн харьцуулалт	34



## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Макро эдийн засгийн 2025 оны төлөв байдал

1.1. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 2.6 хувь, 2025-2026 онд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын зах зээлийн нөлөөгөөр 2.7 хувьд хүрэхээр төсөөлж байгаа хэдий ч геополитикийн хурцадмал байдал даамжирвал дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийг хэлбэлзүүлэх, худалдааны бодлого, сүлжээнд тодорхойгүй байдал, тасалдал үүсгэх эрсдэлтэй байна.

1.2. Инфляц 2024 онд 3.5 хувьд хүрч, хөгжингүй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын төв банк мөнгөний бодлогыг зөөлрүүлэхээ алгуурлаж байгаагаас 2025 онд зээлийн хүү харьцангуй өндөр хэмжээнд хадгалагдсаар байх төлөвтэй байна.

1.3. Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцааны үндсэн сувгууд нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортоор дамжин БНХАУ, цахилгаан эрчим хүч болон шатах тослох бүтээгдэхүүний импортоор дамжин ОХУ-тай тус тус идэвхтэй харилцах замаар хэрэгжиж ирсэн.

1.4. ОХУ-ын хувьд 2024 оны 1 дүгээр улиралд ДНБ 5.4 хувиар өссөн боловч цэрэг армийн зардлаас улбаалж төсвийн зардал тэлсэн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн байна. Инфляцын түвшин нь 2023 оны 12 дугаар сараас аажим өссөөр 2024 оны 05 дугаар сард зорилтот түвшнээс 4.3 нэгжээр давж, 8.3 хувьд хүрсэн байна.

1.5. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 02 дугаар улиралд 4.7 хувь болж өмнөх улирлаас 0.6 нэгжээр буурсан байна. Нүүрсний импорт 2024 оны 5 дугаар сард 44 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөнд Австрали улсаас авах нүүрсний худалдааны хоригийг цуцалж худалдан авалтыг 3 дахин нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

1.6. Дэлхийн банкны эдийн засгийн таамаглалаар Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлтийг 2024 онд 4.8 хувь, 2025-2026 онд 6.3-6.6 хувь байхаар тооцсон байна. Цаг агаарын нөлөөллөөр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл хумигдах, улмаар хүнсний нийлүүлэлттээс үүдсэн инфляц өсөх магадлалтай гэжээ<sup>1</sup>.

1.7. Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5.6 хувьд хүрч өсөхөд уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин өвөлжилтийн хүндрэлээс үүдэж 8.1 сая толгой мал хорогдсоноор хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурчээ.

1.8. Тайлант 2024 оны хагас жилийн байдлаар эдийн засаг сэргэснээр ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувь, өрхийн сарын дундаж орлого 24.0 хувь, үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 99.1 мянга болж өссөн зэрэг үзүүлэлттэй<sup>2</sup> байна.

1.9. Мөн нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурсан хэдий ч гадаад худалдааны эргэлт 13,264.0 сая ам.доллар, тэнцэл 2,508.0 сая ам долларын ашигтай, гадаад валютын албан нөөц 4,839.0 сая ам.доллар, инфляцын түвшин 5.1 хувьтай гарчээ.

1.10. Энэ оны эхний хагас жилийн байдлаарх нийт экспортын 95 хувийг уул уурхайн салбараас бүрдүүлсэн байна<sup>3</sup>. Үүнд:

• Нүүрсний экспорт 40.6 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 37.6 хувиар өсжээ.  
/Гашуунсухайт боомт 20.4 сая тонн, Шивээхүрэн боомт 11.8 сая тонн, Ханги боомт 1.8 сая тонн, бусад боомтуудаар 6.7 сая тонн/;

<sup>1</sup> Эх сурвалж: Worldbank :Global economic prospects, June 2024

<sup>2</sup> Эх сурвалж: Монголбанк

<sup>3</sup> Эх сурвалж: Эдийн засгийн хөгжлийн яам, Макро эдийн засгийн 2024 оны 06 дугаар сарын мэдээ, Сангийн яам





- Зэсийн баяжмалын экспорт 785.2 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувиар өссөн байна. /Гашуун сухайтын (Оюу-Толгой) боомт 487.1 мянган тонн, Замын-Үүдийн (Эрдэнэт) боомт 298.0 мянган тонн/;
- Төмрийн хүдрийн экспорт 3,596.0 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.4 хувиар нэмэгдсэн байна. /Замын-Үүд боомт 3,233.0 мянган тонн, Бургастай боомт 322.0 мянган тонн, бусад боомтууд 41.0 мянган тонн/;
- Газрын тосны экспорт 2,065.0 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар буурчээ. /Баянхошуу боомт 1,894.0 мянган баррель, Замын-Үүд боомт 171.0 мянган баррель газрын тос/

1.11. Эдийн засаг, хөгжлийн яам нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1<sup>4</sup>-т заасны дагуу 2025 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөллийг тооцоходоо ДНБ-ийг 95,010.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 19.9 хувь, инфляцын түвшин 7.5 хувьд хүрч өмнөх оноос 1 нэгжээр тус тус өсөхөөр таамагласан байна.

Хүснэгт 1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл

Макро эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 ХБГ	2025 төс	Өсөлтийн хувь 2024/2025
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	43,555	53,852	70,442	79,216	95,010	19.9
Уул уурхайн	тэрбум төгрөг	10,754	12,402	19,814	22,815	30,510	33.7
Уул уурхайн бус	тэрбум төгрөг	32,802	41,449	50,627	56,400	64,500	14.4
Эдийн засгийн өсөлт	хувь	1.6	5.0	7.4	5.6	8.0	2.4
Уул уурхайн	хувь	0.8	-15.3	23.4	13.5	16.2	2.7
Уул уурхайн бус	хувь	1.8	8.2	5.4	4.5	6.7	2.2
Инфляц /жилийн дундаж/	хувь	7.3	15.2	10.4	6.5	7.5	1.0

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

1.12. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 -т заасны дагуу 2025-2027 макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн дээд хязгаарыг судалгааны DIGNAR-19 загвар, NRG1 загварыг ашиглан тооцоолсноос дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийн доод хязгаарыг 84,424.6 тэрбум төгрөг, дээд хязгаарыг 101,000.0 тэрбум төгрөг байхаар төсөөлж Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.

1.13. Эдийн засаг, хөгжлийн яам Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг хүлээн авч Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулан Засгийн газарт хүргүүлж, Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр уг хуулийг хэлэлцэн баталжээ.

1.14. Эрх бүхий байгууллагуудын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг тооцсон арга, аргачлал харилцан адилгүй, төсөөлсөн дүн материаллаг хэмжээний зөрүүтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, баталгаажуулахад “хангалттай” бөгөөд “зохистой” байх нотлох баримтын шаардлагыг хангахгүй, аудитын дүгнэлт бодит бус гарах эрсдэлийг дагуулж байна.

<sup>4</sup> дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлага, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг баримтлан боловсруулж, холбогдох тооцоо, дүн шинжилгээний хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх



1.15. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9<sup>5</sup>-д төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогын зорилттой нийцсэн байх эрх зүйн зохицуулалттай.

1.16. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д “Монгол банк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих...” гэж заасан нь төсвийн төслийг боловсруулах хугацаатай цагалбарын хувьд зөрүүтэй байна.

1.17. Монгол банк нь цар тахлын сөрөг нөлөө, геополитикийн эрсдэл зэргээс шалтгаалан 2019-2022 онд мөнгөний бодлогын төлөвийг шат дараатайгаар чангаруулсан бол 2023-2024 онд төсвийн тэлэлттэй холбоотойгоор бодлогын хүүг өндөр хэвээр хадгалсан байна.

1.18. Монгол банкнаас хийсэн судалгаагаар “2025 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ДНБ-ий 37.7 хувьд хүрч тэлэх нь дотоодын эрэлтийг тэлж, 2025 онд инфляцад 1-2 хувийн нэмэлт дарамт бий болгох, төсвийн томоохон хөрөнгө оруулалтыг гадаад санхүүжилтээр шийдвэрлэх боломжгүй нөхцөлд төлбөрийн тэнцэл, инфляц эрчимжих эрсдэлтэй” гэж дүгнэсэн байна.

1.19. Монгол банкнаас цаашид инфляцыг төв банкны зорилтот түвшинд тогтвортой хадгалах, мөнгөний болон төсвийн бодлогын уялдааг хангах хүрээнд төсвийн зардлыг (ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй) огцом нэмэгдүүлэхгүй байх чиглэлд Засгийн газрыг анхаарах шаардлагатай гэж үзжээ.

1.20. Харин Засгийн газрын зүгээс экспортын орлогыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлж, гадаад худалдааны тэнцвэрийг хадгалах, хүнсний хангамжийг сайжруулах зэрэг санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлснээр инфляцыг сааруулах ба төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавьсан байна.

1.21. Монгол Улс 2024 онд тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт олон улсын индексээр өмнөх онтой харьцуулахад 7 байр урагшилсан боловч “уур амьсгалын өөрчлөлт” зорилтын хэрэгжилт буурсан үзүүлэлттэй, 2030 он гэхэд зорилтот түвшинд хүрэхгүй төлөвтэй байна.

### **Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны хагас жилийн гүйцэтгэл, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төлөвлөлт**

1.22. Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 25,855.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 27,360.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,505.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тус тус баталсан.

1.23. Төсвийн гүйцэтгэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 14,198.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 12,911.3 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,287.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

1.24. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд 126 гишүүнтэй шинэ парламент бүрдэж, хамтарсан Засгийн газар байгуулагдан хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор 2024 оны төсөвт тодотгол хийсэн.

1.25. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.4 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30,487.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.5 хувь, нэгдсэн төсвийн

<sup>5</sup> 27.1.9.төрийн мөнгөний бодлогын зорилтод нийцсэн байх



тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,615.4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар баталсан.

1.26. Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хуулийн төсөл, түүнийг дагалдуулж 5 хууль, УИХ-ын 3 тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.27. Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх бодлого баримталжээ.

1.28. Бодлогыг хэрэгжүүлэх үүднээс “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, намуудын мөрийн хөтөлбөрт туссан онцлог заалтуудыг нэгтгэж, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх үүднээс дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Хөгжлийн хөрөнгө оруулалт, бүсийн томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх;
- Бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдсан татварын бодлого хэрэгжүүлэх;
- Төрийн өмчит компани болон төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг өсгөх;
- Боловсруулах үйлдвэрийг татварын бодлогоор дэмжих;
- Үндэсний баялгийн сангаар дамжуулан үндэсний орон сууцжуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

1.29. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 33,864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 35,795.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.7 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,909.5 тэрбум төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2.0 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар тус тус төлөвлөжээ.

Хүснэгт 2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, /тэрбум төгрөгөөр/

Төсвийн эдийн засгийн ангилал	МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ		МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН				
	Мөнгөн дүн	ДНБ-д эзлэх хувь	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	НДС- гийн төсөв	ЭМДС- гийн төсөв	ҮБС- гийн төсөв
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>36,830.5</b>	<b>38.8</b>	<b>23,749.5</b>	<b>7,756.1</b>	<b>6,943.8</b>	<b>2,525.6</b>	<b>2,356.8</b>
Тогтворжуулалтын сан	608.9	0.6	608.9				
Үндэсний баялгийн сан	2,356.8	2.5					2,356.8
<b>Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>33,864.7</b>	<b>35.6</b>	<b>23,140.6</b>	<b>7,756.1</b>	<b>6,943.8</b>	<b>2,525.6</b>	<b>-</b>
Татварын орлого	31,939.9	33.6	19,633.3	6,276.3	5,491.3	2,525.6	-
Татварын бус орлого	1,924.8	2.0	3,507.3	1,479.8	1,452.5	-	-
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>35,795.2</b>	<b>37.7</b>	<b>26,508.6</b>	<b>7,756.1</b>	<b>5,815.5</b>	<b>2,216.3</b>	<b>-</b>
Урсгал зарлага	26,036.4	27.4	19,840.8	4,520.3	5,882.8	2,293.9	-
Хөрөнгийн зардал	9,803.8	10.3	6,568.0	3,235.8	0.0	0.0	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-45.0	0.0	99.8	0.0	-67.2	-77.6	-
<b>Нэгдсэн төсвийн суурь тэнцэл</b>	<b>1,909.5</b>	<b>2.0</b>					
Төсвийн тэнцэл (тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон)	-1,930.5	2.0	-3,368.0	0.0	1,128.2	309.3	-
<b>Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,930.5</b>	<b>2.0</b>	<b>3,368.0</b>	<b>0.0</b>	<b>-1,128.2</b>	<b>-309.3</b>	<b>-</b>

Эх сурвалж: Сангийн яам



1.30. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөвт нийт 36,830.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс тогтворжуулалтын санд 608.9 тэрбум төгрөг, үндэсний баялгийн санд 2,356.8 тэрбум төгрөгийг тус тус хуримтлуулахаар төлөвлөсөн байна.

1.31. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн тухай хуулийн болон бусад хуулийн төсөл, тооцооллын уялдааг хангах, төлөвлөлтийн чанарыг дээшлүүлэх үүднээс дараах өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 6.1-д заасан Төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд төлөвлөгдсөн үнэт цаас, гадаадын зээл тусламжаар санхүүжих хөрөнгө оруулалтын 2,035.0 тэрбум төгрөгийн зардлыг хуулийн төсөлд эдийн засгийн ангиллын дагуу тусад нь төлөвлөх;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон цэвэр зээлийн буцаан төлөлт 332.0 тэрбум төгрөгийг хуулийн төсөлд эдийн засгийн ангиллын дагуу тусад нь төлөвлөх;
- Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн “сайн дураар даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого 279.3 тэрбум төгрөгийг 16.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 295.8 тэрбум төгрөгөөр, бусад орлого 53.2 тэрбум төгрөгийг 16.5 тэрбум төгрөгөөр бууруулж, бүлэг хооронд залруулан төлөвлөх;
- Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 36,830.5 тэрбум төгрөгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хүүгийн орлогын 55.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 36,885.5 тэрбум төгрөгөөр тооцох, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар төлөвлөлтийн уялдааг хангах;

## **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОЛОН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН БОЛОВЧ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙГЭЭС ТҮҮНД ЧИГЛЭСЭН ЭСЭХИЙГ ДҮГНЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА**

2.1. Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д заасны дагуу төсвийн төслийн танилцуулга мэдээллийг хуульд заасан дарааллын дагуу, иж бүрэн байдлаар ирүүлэх шаардлагатай байна. Тухайлбал: Төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ гэж заасан байхад эрсдэлийн тойм мэдээг ирүүлсэн, ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр ирүүлсэн боловч тэдгээртэй холбогдсон тайлбар танилцуулга бүрэн бус, санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар ирүүлээгүй байна.

2.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1<sup>6</sup>-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулахаар заасан байна.

2.3. Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 4 зорилго, нийт 626 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2.4. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан хөтөлбөрт нийцүүлэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд 65 арга хэмжээг бүрэн, 366 арга хэмжээг агуулгын хувьд хэсэгчлэн санхүүжүүлэхээр тусгасан байна.

<sup>6</sup> 9.5.1.улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;



**Хүснэгт 3. Монгол Улсын хөгжлийн бодлого болон төсөв хоорондын уялдаа /тэрбум төгрөг/**

Бодлогын чиглэл	Нийт арга хэмжээ нийт тоо	Хөрөнгө оруулалтын шинжтэй		Үүнээс			Нийт
		Үгүй	Тийм	Төсөлд тусгагдсан	УТХО-р хэрэгжүүлэх	ГЗТ-р хэрэгжүүлэх	
<b>НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>92</b>	<b>31</b>	<b>61</b>	<b>24</b>	<b>426.6</b>	<b>383.0</b>	<b>809.6</b>
1.1. Улаанбаатар хот - “20 минутын хот” стандарт	34	11	23	12	132.8	270.8	403.6
1.2. Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот	11	6	5	2	210.0	0.0	210.0
1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил	31	2	29	8	83.0	100.0	183.0
1.4. Орон нутгийн хөгжил	16	12	4	2	0.8	12.1	12.9
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	<b>152</b>	<b>142</b>	<b>10</b>	<b>6</b>	<b>555.0</b>	<b>213.6</b>	<b>768.6</b>
2.1. Чинээлэг монгол хүн	68	67	1	1	8.1	11.2	19.3
2.2. Эрдэм боловсролтой монгол хүн	41	37	4	3	511.9	-	511.9
2.3. Эрүүл монгол хүн	18	17	1	1	35.0	0.0	35.0
2.4. Баялагтаа эзэн монгол хүн	25	21	4	1	-	202.4	202.4
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>	<b>228</b>	<b>143</b>	<b>85</b>	<b>25</b>	<b>2,959.6</b>	<b>695.2</b>	<b>3,654.8</b>
3.1. Эдийн засгийн эрх чөлөө	18	18	-	-	-	-	-
3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын орчин	23	22	1	1	-	14.1	14.1
3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал	160	79	81	22	2,940.2	601.1	3,541.3
3.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт	27	24	3	2	19.4	80.0	99.4
<b>ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>	<b>154</b>	<b>140</b>	<b>14</b>	<b>10</b>	<b>233.3</b>	<b>220.8</b>	<b>454.1</b>
4.1. Хүний эрх, эрх чөлөө	33	32	1	1	70.5	-	70.5
4.2. Авлигагүй засаглал	39	38	1	1	32.1	-	32.1
4.3. Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл	19	18	1	1	-	211.6	211.6
4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм	63	52	11	7	130.8	9.1	139.9
<b>Нийт дүн</b>	<b>626</b>	<b>456</b>	<b>170</b>	<b>65</b>	<b>4,174.6</b>	<b>1,512.6</b>	<b>5,687.2</b>

Эх сурвалж: Сангийн яам

2.5. Засгийн газраас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ...” гэж заасны дагуу улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн боловч батлагдаагүй байна.

2.6. Иймд Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэх боломжгүй байна.

**Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.**

2.7. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4.3.1-д “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна” гэж заасан байна.

2.8. Өмнөх аудитаар төсвийн төслийг үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлж, дүгнэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгах талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.



2.9. Иймд төсвийн төсөлд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгасан хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан “аюулгүй байдал”-ыг хангахад чиглэсэн эсэхэд иж бүрэн дүгнэлт өгөх боломж хязгаарлагдмал байна.

2.10. Монгол Улсын 2025 төсвийн төслийг боловсруулахад чиглэсэн бодлого нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд агуулгаараа нийцэж байна. Тухайлбал:

2.11. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2. “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын 3.2.1.3-д “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна” гэсэн бодлогын хүрээнд дараах арга хэмжээ хамаарч байна. Үүнд:

- Ирээдүйн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн, уул уурхайн орлогоос бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал, санаачилга дээр тулгуурлан зарцуулагддаг ОНХС-гийн хуваарилалтаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймаг, сумдад түлхүү хуваарилах;
- Татварын ялгаатай бодлогыг ирэх оноос эхлэн хэрэгжүүлж эхэлнэ. Энэ хүрээнд нийт 20 төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломж бүрдэж, бүс орон нутаг бие даан эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлж бизнес, хөрөнгө оруулалт татах, хоорондоо өрсөлдөх боломжийг бүрдүүлэх;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа нэвтэрснээр биржээр борлуулах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, эдгээр бүтээгдэхүүний үнэ зах зээлийн, шударга өрсөлдөөний зарчмаар илүү бодитой тогтоох;
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан бүсүүдийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийн хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн санхүүжүүлэлтийг чиглүүлэх;
- Хот хөдөөгийн сэрэгэлт, төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах.

2.12. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2. “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын 3.2.2.5-д “Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн бодлогын хүрээнд дараах арга хэмжээ хамаарч байна. Үүнд:

- Засгийн газар 2025 онд боомтын шинэчлэлийг үргэлжлүүлэн боомтын үйл ажиллагааг цахимжуулах, хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг сайжруулах;

2.13. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2. “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын 3.2.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн бодлогын хүрээнд дараах арга хэмжээ хамаарч байна. Үүнд:

- Ирэх 2025 онд 226.2 мянган төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэхээр, ингэснээр төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг (суманд 1,632.4 мянган төгрөг, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт 1,399.2 мянган төгрөг), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг (суманд 1,335.6 мянган төгрөг, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт 1,144.8 мянган төгрөг) болж, 2025 онд төсөвт төвлөрүүлэх хувь хүний орлогын албан татварын орлого энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 586.5 тэрбум төгрөгөөр буюу 25.2 хувиар өсөж, 2,918.3 тэрбум төгрөгт хүрэхээр тооцоолсон байна.



## ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА

3.1. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

Тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгасан байдал	Шалгуурыг хангасан байдал
6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129.0 ам.доллар байхаар тооцсон байна.	<b>Шаардлага хангасан</b> Гол нэр төрлийн эрдэс баялаг болох зэсийн баяжмалаас 2,949.7 тэрбум төгрөг буюу нийт орлогын 8 хувь, нүүрснээс 7,125.5 тэрбум төгрөг буюу нийт орлогын 19 хувийг тус тус бүрдүүлэхээр байна. Зэсийн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 129.0 ам.доллар байхаар тооцсон байна.
6.1.2. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,909.5* тэрбум төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна.	<b>Шаардлага хангасан</b> Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд ДНБ-ийг 95,010.0 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 33,864.7 тэрбум төгрөг, суурь зарлагын дүнг 31,955.2 тэрбум төгрөг байхаар тус тус төлөвлөжээ. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,909.5 тэрбум төгрөгийн ашигтай байгаа нь ДНБ-ийн 2.0 хувьтай тэнцэж байна.
6.1.3. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг 26,036.4* тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.4* хувьтай тэнцэхээр төлөвлөжээ.	<b>Шаардлага хангасан</b> Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн урсгал зардал 26,036.4 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий 27.4 хувьтай тэнцэж байна.
6.1.4. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх;	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2023-2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.	<b>Шаардлага хангасан</b> Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг 40,493.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2025 оны ДНБ 95,010.0 тэрбум төгрөгийн 42.6 хувьтай тэнцэж байна.

Эх сурвалж: Үндэсний аудитын газар, Сангийн яам /Хуулийн төслийн хавсралт/



3.2. Төсвийн төсөл нь дээрх шаардлагыг хангахаас гадна Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3<sup>7</sup>, 6.5<sup>8</sup>, 6.6<sup>9</sup> -д заасан шаардлагад нийцсэн байна.

*Хүснэгт 5. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан бусад шалгуурыг хангасан байдал*

Хуульд тусгасан бусад шалгуур	Шалгуурыг хангасан байдал
6.3. Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.	<b>Шаардлага хангасан</b> Засгийн газрын дотоод үнэт цаасаар баталгаажсан өрийн баталгаа байхгүй байна.
6.5. Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулах, 6.1.4-т заасан тусгай шаардлагын дээд хэмжээг нэмэгдүүлэхийг хориглоно.	<b>Шаардлага хангасан</b> Тус хуулийн 6.1.2, 6.1.4-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь ДНБ-ий 2 хувьтай, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь ДНБ-ний 42.6 хувьтай тэнцэж байна.
6.6. Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.	<b>Шаардлага хангасан</b> 2025 оны төсвийн жилд засгийн газрын урт хугацаат дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 211.5 тэрбум төгрөг, урт хугацаат гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 243.1 тэрбум төгрөг, гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 816.9 тэрбум төгрөг, гадаад хөтөлбөрийн зээлийн үндсэн төлбөрт 638.0 тэрбум төгрөг, нийт 1,909.5 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөсөн байна.

*Эх сурвалж: Үндэсний Аудитын газар*

**Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг байдал давтагдаж байна**

3.3. Засгийн газар нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2<sup>10</sup>-т заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан батлуулах, жилийн төсвийн төслийг тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3<sup>11</sup>-т заасны дагуу батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төлөвлөх үүрэгтэй.

3.4. Засгийн газраас өргөн мэдүүлж, 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн зарим үзүүлэлтүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тооцсон макро эдийн засгийн үзүүлэлтээс зөрүүтэй байна.

<sup>7</sup> Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.

<sup>8</sup> Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулах, 6.1.4-т заасан тусгай шаардлагын дээд хэмжээг нэмэгдүүлэхийг хориглоно

<sup>9</sup> Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна

<sup>10</sup> дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

<sup>11</sup> Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.





**Хүснэгт 6. Төсвийн хүрээний мэдээдлийн таамаглал болон хууль хоорондын зөрүү**

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт	ТТБЗ-ийн тооцсон таамаглалын дээд хязгаар	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдээдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль	Батлагдсан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2024.08.29/	Зөрүү				
				Таамаглалын дээд хязгаар/ батлагдсан хууль	Батлагдсан хууль/ хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл			
<b>2025 оны төсвийн хүрээний мэдээдэл</b>								
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.7	8.0	8.0	1.3	-		
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	6.0	7.5	(2.0)	1.5		
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	26,170.2	29,400.1	33,864.7	3,229.9	4,464.6		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	25.9	30.9	35.6	5.0	4.7		
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	27,774.0	31,300.4	35,795.2	3,526.4	4,494.8		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27.5	32.9	37.7	5.4	4.8		
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(2,020.0)	(1,900.3)	(1,930.5)	119.7	(30.2)		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	(2.0)	(2.0)	(2.0)	-	-		
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	Энэ үзүүлэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн		31,955.2	-	31,955.2		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь			33.6	-	33.6		
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/			1,909.5	-	1,909.5		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь			2.0	-	2.0		
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/			60,600.0	47,507.1	52,255.5	(13,092.9)	Өөрчлөлтгүй*
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь			60.0	50.0	55.0	(10.0)	
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/			2,727.0	2,850.4	2,572.3	123.4	(278.1)
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.7	3.0	2.7	0.3	(0.3)		
А	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	413.5	3,939.9	Энэ үзүүлэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хассан	3,526.4	-		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.4	4.1		3.7	-		
Б	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,999.8	7,273.3		2,273.5	-		
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.0	7.7		2.7	-		

Эх сурвалж: Үндэсний аудитын газар /\*-төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу Засгийн газрын өрийг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэж байсныг нэрлэсэн дүн болгосон./

**3.5. Дараах хүчин зүйлсээс шалтгаалан зөрүү үүссэн байна. Үүнд:**

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдээдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар баталсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын үндэсний зөвлөлийн макро эдийн засгийн таамаглалын орлогын дээд хязгаараас 3,229.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь нүүрсний экспортын биет хэмжээний тооцооллын зөрүүнээс (ТТБЗ 50 сая тонн, ЭЗХЯ сая тонн) шалтгаалсан байна. Өмнөх буюу 2023 оны бодит гүйцэтгэлээр Монгол Улс нийт 69.9 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд цаашид нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан үзэх шаардлагатай байна;



- Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг ТТБЗ-с тооцоолсныг 3,526.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Засгийн газраас төрөөс олгох цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна;
- Засгийн газрын өрийн нийт хэмжээг ТТБЗ-с тооцсон дүнгээс 13,092.9 тэрбум төгрөгөөр бууруулж 47,507.1 тэрбум төгрөгөөр баталсан нь Засгийн газраас зээлжих зэрэглэлийг үе шаттайгаар сайжруулах, Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийг оновчтой хэрэгжүүлэх үүднээс 2024 оны эхний улирлын бодит гүйцэтгэл /33.7 хувь/-тэй уялдуулан төлөвлөсөнтэй холбоотой байна. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр орсон өөрчлөлтийн дагуу өрийн үлдэгдлийг нэрлэсэн үнээр тооцож эхэлжээ.

3.6. Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай батлагдсан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3<sup>12</sup>, 7.4<sup>13</sup>-д заасантай бүрэн нийцэхгүй байна.


## ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ГОЛЛОХ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН БУУРАЛТААС ШАЛТГААЛЖ ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

4.1. Монгол Улсын 2025 оны нийт орлого ба тусламжийн дүнг 2024 оны төсвөөс 6,190.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 36,830.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 38.8 хувьд хүрэх төлөвтэй байна. Үүнд: Тогтворжуулалтын санд 608.9 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн санд 2,356.8 тэрбум төгрөгийг хуримтлуулж, татварын орлогоос 31,939.9 тэрбум төгрөг, татварын бус орлогоос 1,924.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тусгажээ.

4.2. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 4,992.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 33,864.7 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн нь худалдааны эргэлт, экспортыг дэмжих, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах, уул уурхайн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлж төлөвлөсөнтэй холбоотой байна.

4.3. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын хувь 2025 онд 33.6 хувь буюу өмнөх оноос 0.4 нэгжээр буурах, төвлөрүүлэх дүн 31,939.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 5,000.7 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.

Дүрслэлт 1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын харьцуулалт /хувиар/



Эх сурвалж: Сангийн яам

<sup>12</sup> Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.

<sup>13</sup> Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд ... дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.



4.4. Монгол Улсын 2025 оны төсвийн нийт орлогын 31.7 хувь буюу 11,689.5 тэрбум төгрөгийг уул уурхайн салбарын орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

4.5. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний биет хэмжээг 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 0.2-5.2 нэгжээр нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 7. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ

Бүтээгдэхүүн	Экспортын биет хэмжээ									
	хэмжих нэгж	2022 он		2023 он		2024 он			2025 он төс.	Зөрүү 2024 ХБГ /Төс
		Төл.	Гүйц	Төл.	Гүйц	Төл.	Гүйц. 2024.08.31	ХБГ		
Нүүрс	сая.тн	18.0	31.8	50.0	69.6	60.0	55.4	78.1	83.3	5.2
Зэсийн баяжмал	сая.тн	1.2	1.5	1.5	1.5	1.5	1.05	1.6	1.8	0.2
Алт /МБ-нд тушаасан, цэвэр жингээр/	тн	20.0	17.7	20.0	12.4	20.0	7.1	18.0	18.0	-
Төмрийн хүдэр	сая.тн	5.1	4.7	8.4	5.7	8.4	4.8	8.4	9.0	0.6
Боловсруулаагүй нефть	сая. бар	3.4	2.6	6.5	4.7	4.9	2.8	4.2	5.4	1.2

Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ

4.6. Уул уурхайн салбараас 2025 оны төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого БНХАУ-ын эдийн засгийн байдал, үл хөдлөх хөрөнгийн салбарын болон коксжих нүүрсний эрэлт багасах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурах зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр тасалдах эрсдэлтэй, төсвийн эх үүсвэрийн дутагдлыг бусад салбараас нэмж бүрдүүлэх боломж хомс байна.

4.7. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дэлхийн зах зээлд 2025 онд өмнөх оноос тонн тутамд зэсийн дундаж үнэ 500.0 ам.доллаароор өсөх бол алтны үнэ унц тутамд 350.0 ам доллароор, тонн тутамд төмрийн хүдэр 20.0 ам.доллар, нүүрсний үнэ 35.0 ам.доллар, газрын тосны үнэ баррель тутамд 5.0 ам.доллаароор тус тус буурах төлөвтэй байна.

Хүснэгт 8. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн харьцуулалт

Бүтээгдэхүүн	2024 оны тод.төс	2025 оны төл.төс	Зөрүү	ОУ-ын шинжээчдийн таамагласан өөрчлөлт
Нүүрс ам.доллар/тонн	115.0	105.0	▼ 10.0	▼ 35.0
Зэс ам.доллар/тонн	9,500.0	10,000.0	▲ 500.0	▼ 500.0
Алт ам.доллар/унц	2,200.0	1,850.0	▼ 350.0	▲ 350.0
Газрын тос ам.доллар/баррель	80.0	77.0	▼ 3.0	▼ 5.0
Төмрийн хүдэр ам.доллар/тонн	78.0	65.0	▼ 13.0	▼ 20.0

Эх сурвалж: Сангийн яам, ЭЗХЯ

4.8. Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээг 9.0 сая тонн, борлуулах үнийг 65 ам.доллар байхаар 2025 оны төсвийн төсөлд тусгажээ. Гэтэл төмрийн хүдрийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 8.4 сая тонн, 8 сард бодит гүйцэтгэлээр 4.8 сая тонн төмрийн хүдрийг экспортод гаргасан байна.

4.9. Мөн 2025 онд нийт 83.3 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн бөгөөд үүний 37.9 сая тонн буюу 45.5 хувийг Эрдэнэс таван толгой ХК дангаараа эзэлж байна. Монгол улс 2024 оны 8 сарын бодит гүйцэтгэлээр 55.4 сая тонн нүүрс экспортолсноос тус компани 21.6 сая тонн нүүрсийг экспортолсон нь ирэх жилийн зорилтод түвшинд хүрэхэд хүндрэл үүсэж болзошгүй юм.



4.10. Монгол Улсын Засгийн газраас экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр экспортын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.

4.11. Үндэсний аудитын газраас 2023 онд “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар цааш дамжуулах өртөөдийн тээх, нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлт хийх хөдлөх бүрэлдэхүүн хүрэлцээгүйгээс суурилагдсан хүчин чадлынхаа 18.6 хувийг ашиглахаар, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хувьд хил холболтын цэгийг урьдчилан тохиролцоогүйгээс төмөр замаар хил дамжуулан тээвэрлэлт хийх боломжгүй зам болсон байна” гэж дүгнэсэн.

4.12. УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 1-т “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг 2025 онд барихаар төлөвлөсөн.

4.13. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэхээр байна. Иймд төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг цаг алдалгүй эрчимжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ашиглалтад оруулснаар нүүрсний борлуулалтыг нэмэгдүүлэхэд түлхэц өгөхүйц байна.

4.14. Засгийн газрын зүгээс уул уурхайн салбарын бүтээгдэхүүнээс бий болох үр өгөөжийг бүрэн дүүрэн ашиглахад анхаарч дагалдах ашигт малтмалд ноогдох АМНАТ-ын орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал:

4.15. Татварын ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтаар тогтоосон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2016-2018 оны татварын ногдуулалт, төлөлттэй холбоотой нийт 33.1 тэрбум төгрөгийн, “Оюу толгой” ХХК-ийн 2013-2020 оны татварын ногдуулалт, төлөлтөд дагалдах элементтэй холбоотой 62.5 тэрбум төгрөгийн татварыг төлүүлэх шийдвэр одоог хүртэл хэрэгжээгүй шүүхийн маргаан хянан шийдвэрлэх шатанд байна.

4.16. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжсэнээр ашигт малтмалын экспортын ил тод, нээлттэй байдал, түүнд тавих олон нийтийн хяналт сайжирч, далд эдийн засгийг бууруулах эерэг үр дагаврыг бий болгосон нь төсвийн орлогын бүрдүүлэлтэд эергээр нөлөөлөхөөр байна.

4.17. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд татварын бус орлогыг 2024 оны тодотголоор баталсан дүнгээс 0.4 хувиар бууруулж, 1,924.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

4.18. Татварын бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд дараах орлого тасарч болзошгүй байна. Үүнд:

- Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөө, ОХУ-Украины дайн зэрэг хүндрэлүүдээс шалтгаалан 2019 оноос 2022 онд олон улсын нислэгийн хөөрөлт, бууралтын тоо болон навигацийн орлого буурсан бөгөөд 2024 оны 7 дугаар сарын байдлаар нийт 36,740 өнгөрөлтийн нислэг үйлдэгдсэн нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 74 хувиар өссөн үзүүлэлттэй боловч зардлын дүн өсөж төсөвт төвлөрүүлэх орлогыг бууруулсан байна.
- Нийт 607.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр төлөвлөсөн төрийн өмчит болон өмчийн оролцоотой 44 хуулийн этгээдийн өмнөх онуудад төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн дүнг харьцуулан үзэхэд 2022 онд 26 хуулийн этгээд нь нийт 470.8 тэрбум төгрөгийн, 2023 онд 37 хуулийн этгээд 422.0 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн



этгээдийн цэвэр ашиг өсөж байгаа хэдий ч эргэлтийн хөрөнгийн байдал болон хөрөнгө оруулалтын зардал зэргээс шалтгаалан төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

**Зарим төрлийн импортын бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, татварын хуримтлагдсан өрийг барагдуулснаар орлого нэмэгдэх боломжтой байна.**

4.19. Татварын өр 2024 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,714.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгааг 2025 онд барагдуулах арга хэмжээ авснаар төсвийн орлого нэмэгдэх боломжтой байна.

4.20. Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтээр УИХ-д “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, электрон тамхинд албан татвар ногдуулах нөхцөл бүрдүүлэх” асуудлыг толилуулсан.

4.21. УИХ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолын 1.8-д “Электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах асуудлыг судлан үзэж, шаардлагатай бол холбогдох хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан УИХ-д өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт даалгасан байна.

4.22. Сангийн яамнаас 2023 оны Төсвийн тухай хуультай хамт Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Эрүүл мэндийн яамнаас Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ хуулийг дагалдуулан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан боловч хэрэгжилт удаашралтай байна.

4.23. ДЭМБ-аас тогтоосноор Монгол Улсад өсвөр насны хүүхдийн тархины хөгжилд электрон тамхины хэрэглээ нь урт хугацаанд сөргөөр нөлөөлж, эрүүл мэнд, амь насанд нь аюул, эрсдэл учруулж байгаа тул электрон тамхины импорт, хэрэглээнд хяналт тавьж, татварын бодлогоор дамжуулан нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврын нөлөөг бууруулах, урьдчилан сэргийлэх нь зүйтэй байна.


## **ТАВ. ЗАСГИЙН ГАЗАР УРСГАЛ ЗАРДЛЫГ ӨМНӨХ ОНООС 3,565.6 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР ТӨСВИЙН ХЯЗГААРЫГ ХЭТРҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА**

5.1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2024 оны төсвөөс 5,307.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 35,795.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд: Урсгал зардал 26,036.4 тэрбум, хөрөнгийн зардал 9,803.8 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 45.0 тэрбум төгрөг байна.

5.2. Төсвийн урсгал зардал 2017 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй, 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 72.7 хувь буюу 26,036.4 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна.



Дүрслэл 2. Нийт зарлага /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

5.3. Төсвийн төслийн нийт урсгал зардлын 42.5 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, 28.9 хувийг цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 19.3 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зардал, 5.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 4.3 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

5.4. Урсгал зардлыг 2024 оны төсвөөс 3,565.6 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өсгөж төсөвлөсөн нь төсвийн бодлогод туссан дараах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тавьсантай холбоотой байна. Үүнд:

- Хүний хөгжлийг дэмжсэн, хүний эрхийг дээдэлсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшлийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэх;
- Баялагтаа эзэн Монгол, иргэдийг орон сууцжуулах багц арга хэмжээг санхүүжүүлэх;
- Хүн амын өсөлт, үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой зардлыг санхүүжүүлэх.

5.5. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3<sup>14</sup>-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн саналыг Сангийн яам болон Төрийн аудитын байгууллагад тус тус хүргүүлэхээр зохицуулсан.

5.6. Монгол улсын 2025 оны төсөвт Төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийт 37,709.8 тэрбум төгрөгийн урсгал зардал зарцуулах санал ирүүлснийг 26,036.4 тэрбум төгрөгөөр хянаж төсвийн төсөлд тусгасан байна.

5.7. Нийт урсгал зардлын 76.2 хувийг улсын төсвөөс, 17.4 хувийг ОН-ын төсвөөс, 22.6 хувийг Нийгмийн даатгалын сангаас, 8.8 хувийг Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

<sup>14</sup> 8.4.3.төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх;



Хүснэгт 9. Төсвийн шатлалаар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны төсөв	2025 Хязгаар	2025 ТЕЗ санал	2025 УИХ өргөн мэдүүлсэн	Хягаар давсан зөрүү	Хувь
Улсын төсвийн зардал	16,467.7	17,629.6	24,431.8	19,840.8	2,211.2	12.5
ОН-ын урсгал зардал	4,176.9	4,891.7	4,154.8	4,520.3	-371.4	7.6
Нийгмийн даатгалын сан	5,188.4	5,480.5	6,241.6	5,882.8	402.3	7.3
Эрүүл мэндийн даатгалын сан	1,933.2	1,971.3	2,881.7	2,293.9	322.6	16.4
Төсөв хоорондын шилжүүлэг	-5,295.3	-6,501.3	-	-6,501.3	-	-
<b>Дүн</b>	<b>22,470.8</b>	<b>23,471.7</b>	<b>37,709.8</b>	<b>26,036.4</b>	<b>2,564.7</b>	<b>10.9</b>

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

5.8. Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн саналыг боловсруулахдаа төсвийн зардлын дээд хязгаар 23,471.7 тэрбум төгрөгөөс 2,564.7 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар хэтрүүлэн төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2<sup>15</sup>-д, 14 дүгээр зүйлийн 14.2.1<sup>16</sup>-д заасантай нийцэхгүй байна.

5.9. Төсвийн урсгал зарлагыг 2024 оны төсөвтэй харьцуулахад цалин хөлс 21.0 хувь, байр ашиглалттай холбоотой 50.0 хувь, эд хогшил урсгал засвар 69.0 хувь, томилолт, зочны зардал 46.0 хувь, хангамж бараа материалын зардал 37.0 хувиар өсгөж төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбоотой 2025 оныг аялал жуулчлалыг дэмжих ажлын хүрээнд Засгийн газраас зээлийн хүүгийн татааст дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ байгуулах шийдвэр гарсантай холбогдуулан үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төлөвлөсөн;
- Цагаан алт, Атарын 4-р аян, Шинэ хоршоо-Чинээлэг малчин, тэрбум мод үндэсний хөдөлгөөн зэрэг үндэсний хөтөлбөр, арга хэмжээний үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн.

5.10. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын төсвөөс төсөвлөлтийн шаардлага хангаагүй дараах арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад өндөр өртөгтэй 2021 оны 10 сард ашиглалтад орсон мэргэжлийн тоног төхөөрөмж “РЭТ/СТ”-ийн засвар үйлчилгээний зардалд 1.6 тэрбум төгрөг төсөвлөсөн ч шаардлагатай сэлбэгийн жагсаалт, баталгааны хуудас зэрэг нотлох баримт байхгүй байна;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т “Энэ хуулийн 36.7-д заасны дагуу тогтоосон орон тоогоор сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулна”, Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор Нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг тогтоосны дагуу нийгмийн халамжийн үйлчилгээг сум, хороонд хүргэх нийгмийн ажилтны тоо тухайн сум, хорооны хүн амын тооноос хамаарах бөгөөд сумын хүн амын тоо 1000-3000 тутамд 1, хорооны хүн амын тоо 3000-5000 хүн ам тутамд 1 байхаар тогтоосон. Энэ хүрээнд 927 нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх тушаал, шийдвэр гараагүй байхад 28.1 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөсөн;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйл 8.4-д заасан журам болон санхүүжилтийн хэмжээг Засгийн газраас тогтоогоогүй байхад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцад хүүхэд залуучуудад соёлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрхийн

<sup>15</sup> 10.1.2.Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар батлах;

<sup>16</sup> 14.2.1.жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;



бичиг төрөөс үнэгүй олгох 18.3 тэрбум төгрөгийн зардлыг мөрдөж ажиллах журам, аргачлалгүй төсөвлөсөн;


- Хууль зүй, дотоод хэргийн сайдын орон тоог Засгийн газрын тогтоол, шийдвэр гараагүй байхад 1,149-өөр, цалингийн санг 34.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн.

5.11. Нийт 39 ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тоог 2025 онд 4.1 мянгаар, цалин, хөлсний зардлыг хязгаараас 1,013.9 тэрбум төгрөгөөр хэтрүүлж, нийт 230.5 мянган орон тоотой 7,535.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна. Үүнд цалин, хөлсний зардлаас 6,564.2 тэрбум, урсгал шилжүүлгээс 971.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар тус тус төлөвлөжээ.

5.12. Цалин, хөлсний зардал нь нийт урсгал зардлын 28.9 хувийг эзэлж байгаа бөгөөд 2025 онд төрийн албан хаагчдын цалин, хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байна.

5.13. Төрийн албан хаагчдын тоо 2010 оноос жилд дунджаар 3.0 хувиар өсөж 2023 оны жилийн эцсийн байдлаар 226.5 мянгад хүрчээ.

Дүрслэл 3. Төрийн албан хаагчийн тоо /албан тушаалын ангилал/



Эх сурвалж: ТАЗ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан

5.14. Нийт төрийн албаны 226.5 мянган албан хаагчдын 67.7 хувийг төрийн үйлчилгээ, 21.0 хувийг төрийн тусгай, 9.6 хувийг төрийн захиргаа, 1.7 хувийг улс төрийн албан хаагчид тус тус эзэлж байна. Үүнээс төрийн үйлчилгээний албан хаагчдын 59.4 хувь нь боловсролын салбарт, 20.2 хувь нь эрүүл мэндийн салбарт, 4.2 хувь нь соёлын салбарт, үлдсэн 16.2 хувь нь бусад салбарт ажиллаж байна.

5.15. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2<sup>17</sup>-д төсвийг шатлал, төсвийн захирагч, эдийн засгийн ангилал, хөтөлбөр, арга хэмжээ, санхүүжих эх үүсвэр тус бүрээр ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана гэж зохицуулсан боловч хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээгээр төсвийг тооцоогүй байна.

<sup>17</sup> 22.2.Төсвийг дор дурдсаны дагуу ангилна:

22.2.1.төсвийн шатлалаар;

22.2.2.төсвийн захирагчаар;

22.2.3.эдийн засгийн ангиллаар;

22.2.4.хөтөлбөрөөр;

22.2.5.арга хэмжээгээр;

22.2.6.санхүүжүүлэх эх үүсвэрээр.





5.16. ТЭЗ нарын 2025 онд хэрэгжүүлэх 102 хөтөлбөр, арга хэмжээг хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр ангилсныг төсөвтэй холбож хянах боломжгүй байна.

5.17. ТЭЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг төсвийн төлөвлөлттэй уялдуулахгүй байгаагаас төсвийн зарцуулалтыг зорилтын хэрэгжилттэй харьцуулан үнэлэх боломжгүй байгаа тул Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд туршиж байгаа үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

### **Нийгмийн даатгалын сангийн төсөв**

5.18. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны нийт орлого өмнөх оноос 1,050.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 6,943.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 7.3 хувийг эзэлж байна.

5.19. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны шимтгэлийн орлогыг 5,491.3 тэрбум төгрөгөөр, зарлагыг 5,882.8 тэрбум төгрөгөөр, улсын төсвөөс олгох татаасыг 1,452.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөжээ.

5.20. Капитал банкнаас авах авлагыг 67.2 тэрбум төгрөгийг барагдуулахаар төлөвлөсөн байна.

#### **Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсөв /тэрбум төгрөг/**

Үзүүлэлт	2024 оны төсөв	2025 оны төсөв	Зөрүү	Хувь
<b>А ОРЛОГО</b>	<b>4,718.2</b>	<b>5,491.3</b>	<b>773.0</b>	<b>16</b>
Ажил олгогч аж ахуйн нэгж, төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	2,563.9	2,844.3	280.4	11
Даатгуулагчаас төлөх шимтгэл	1,833.5	2,291.2	457.7	25
Малчин, ХБХ асарч байгаа эцэг, эхийн улсын төсвөөс төлөх шимтгэл	35.5	37.3	1.8	5
Хүүхдээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн даатгалын сангаас төлөх шимтгэл	12.5	7.3	-5.2	-42
Хүүхдээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэл	8.5	7.3	-1.2	-14
Цаатан иргэдийн шимтгэл	0.2	0.1	-0.1	-50
Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөн төлөх шимтгэл	0	0	0.0	0
Сайн дурын даатгуулагчаас төлөх	223	242.1	19.1	9
Гадаад /БНСУ/-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн шимтгэл	5	6.2	1.2	24
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2.8	2.4	-0.4	-14
Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөн төлөх шимтгэл	0	16.5	16.5	100
Бусад орлого	33.3	36.7	3.4	10
<b>Б. ЗАРЛАГА</b>	<b>5,188.4</b>	<b>5,882.8</b>	<b>694.4</b>	<b>13</b>
Тэтгэврийн даатгалын сан	4,741.1	5,392.0	650.9	14
Тэтгэмжийн даатгалын сан	262.4	281.1	18.7	7
ҮОМШӨ-ний даатгалын сан	61.9	66.7	4.8	8
Ажилгүйдлийн даатгалын сан	123	143	20.0	16
Капитал банкнаас авах НДСангийн авлага	-67.2	-67.2	0.0	0
<b>САНГУУДИЙН НИЙТ ТЭНЦЭЛ: -Ашиг</b>	<b>-470.1</b>	<b>-391.5</b>	<b>78.6</b>	<b>-17</b>
<b>-Алдагдал</b>	<b>-800.9</b>	<b>-753.9</b>	<b>47.0</b>	<b>-6</b>
<b>-Цэвэр</b>	<b>-402.9</b>	<b>-324.3</b>	<b>78.6</b>	<b>-20</b>

Эх сурвалж: Сангийн яам



5.21. Нийгмийн даатгалын сангийн зардлын хязгаар 5,480.5 тэрбум төгрөгөөс 402.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1<sup>18</sup>-д заасантай нийцэхгүй байна.

5.22. Улсын төсвийн татаас нь тэтгэврийн даатгалын сангийн зарлагын өсөлт, тэтгэврийн нөөц санд хөрөнгө бүрдүүлэх зэрэг дараах нөхцөл байдал, хууль эрх зүйн зохицуулалт, бодлогын арга хэмжээнүүдээс шалтгаалан нэмэгдэж байна.

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн. Уг арга хэмжээний оны эхний 3 сарын нөлөөлөл болон ирэх оны тэтгэвэр авагчдын тооны өсөлт (45.6 орчим мянган хүн шинээр тогтоолгож, 27.1 орчим мянган хүний тэтгэвэр зогсоогдон хасагдаж, тэтгэвэр авагчдын тооны цэвэр өсөлт 18.5 мянган хүн болно)-тэй холбоотойгоор нийт 281.3 тэрбум төгрөг нэмэгдэх шаардлага байна;
- Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д заасны дагуу 2025 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийг одоогийн мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлүүлэхэд 18.1 мянган малчин хамрагдан санд 16.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, сангаас 7.8 мянган малчны тэтгэвэрт 30.4 тэрбум төгрөгийн зарлага гарахаар тооцсон байна;
- Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээ: Тэтгэврийн хэмжээг 2025 онд 6.0 хувиар нэмэгдүүлэхэд 300.1 тэрбум төгрөг шаардагдахаар төлөвлөсөн байна;

### Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

5.23. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны нийт орлого ба тусламжийн дүнг 2024 оны төсвөөс 560.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2,525.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2.7 хувийг эзэлж байна.

5.24. Нийт зарлагыг 2024 оны төсвөөс 360.7 тэрбум төгрөг буюу 19 хувиар өсгөж 2,293.9 тэрбум төгрөг, Капитал банкнаас авах 77.6 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, 309.3 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөжээ.

5.25. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хязгаарыг 1,971.3 тэрбум төгрөгөөр тогтоосноос 322.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн 2,293.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөв /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны төсөв	УИХ өргөн мэдүүлсэн	Өмнөх оноос өссөн	Хувь
Орлого	1,964.8	2,525.6	560.8	28.5
Зарлага	1,933.2	2,293.9	360.7	18.6
Авлага	-85.0	-77.6	7.4	8.7
Ашиг, алдагдал	116.6	309.3	192.7	165.2

Эх сурвалж: Сангийн яам

5.26. ТЕЗ-ийн ирүүлсэн саналд эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний зардалд 77.0 хувь буюу 2,209.6 тэрбум төгрөг, эмийн хөнгөлөлтийн зардалд 7.0 хувь буюу 197.3 тэрбум төгрөг, эрсдэлийн сан болон үйл ажиллагааны зардалд 5.0 хувь буюу 144.5 тэрбум төгрөг, бусад урсгал зардалд 11.0 хувь буюу 330.3 тэрбум төгрөгийн зардлыг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

<sup>18</sup> 14.2.1.жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;



Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сан 2025 оны зарлага-тусламж, үйлчилгээний төрлөөр /тэрбум төгрөг/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2024 оны төсөв	2025 ТЕЗ санал	Зөрүү	Хувь
1	Лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,205.5	1,423.1	137.4	11
2	Анхан шат тусламж, үйлчилгээ	455.0	723.7	268.6	59
3	Эмийн үнийн хөнгөлөлт	137.3	197.3	60.0	44
4	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	62.8	62.8	(0.0)	0
5	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн зардал	53.6	124.7	71.1	133
6	Өмнөх оны өглөг	-	218.3	218.3	0
7	Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	16.4	19.8	3.4	21
8	Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардал	-	0.5	0.5	0
9	ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	0.5	0.5	0.0	2
10	ЭМД-ын тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй ЭМБ-д олгох урамшууллын зардал;	2.0	5.0	3.0	150
11	Суурь тарифын өсөлт, тогтоол хоорондын зөрүү	-	106.0	106.0	0
<b>Нийт дүн</b>		<b>1,933.1</b>	<b>2,881.7</b>	<b>948.6</b>	<b>49</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

5.27. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэл 1 сард дунджаар 900.0 мянга ирдгээс 15 орчим хувийг л түүвэрлэн хянаж байгаа нь чанаргүй нэхэмжлэлд санхүүжилт олгох бодит эрсдэл байна.

**Үндэсний баялгийн сангийн төсөв**

5.28. Үндэсний баялгийн сангийн хууль 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан бөгөөд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, түүний төрөл, зориулалт, эх үүсвэрийг тодорхойлох, сангийн хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглүүлсэн байна.

5.29. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсөвт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 1,849.7 тэрбум төгрөг, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчийн этгээдийн ногдол ашгаас 507.1 тэрбум төгрөг, нийт 2,356.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

5.30. Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг төв банканд байршуулж байгаа бөгөөд сангийн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээний дагуу 2025 онд 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олохоор төлөвлөсөн байна.

**Орон нутгийн төсөв**

5.31. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн суурь орлого, зарлагын саналыг Сангийн яам хянаж, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн 2025 оны суурь орлогыг өмнөх оноос 1,101.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 6,366,1 тэрбум төгрөгөөр, суурь зарлагыг 964.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 4,830.6 тэрбум төгрөгөөр тус тус төсөвлөсөн байна;
- Орон нутгийн төсвөөс улсын төсөв төвлөрүүлэх дүнг 2024 оноос 307.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,903,1 тэрбум төгрөгөөр тооцсон байна. Үүнд Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгууд байна;
- Улсын төсөвт орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн дээрх аймгуудаас бусад аймгуудад 527.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг улсын төсвөөс олгохоор төлөвлөжээ.



5.32. Монгол Улсын 2025 оны орон нутгийн суурь зардалд төлөвлөгдсөн доорх зардлыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1<sup>19</sup>-д заасны дагуу дараагийн аудитаар хянах шаардлагатай байна. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад байгууллагын чиг үүрэгтэй давхиулж төлөвлөсөн 1.4 тэрбум, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах, мэдээ дата боловсруулах систем, мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлага хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ зэрэг санхүү бүртгэлтэй холбоотой зах зээлийн үнээс өндөр 1.1 тэрбум, бүтээлч хот төсөл, төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх 1.9 тэрбум төгрөг нийт 4.4 тэрбум төгрөг төлөвлөсөн;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2025 онд шинээр ашиглалтад орох 38 сургууль, цэцэрлэгийн урсгал зардалд 6.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн ч 2025 онд ашиглалтад орох эсэх нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байна;
- Нийслэлийн засаг даргын тамгын газар Шинэ жилийн баярын цэнгүүн зохион байгуулах арга хэмжээ, олон улсын "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ 1.4 тэрбум төгрөг.

## ЗУРГАА. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ТОМООХОН ТӨСЛҮҮДЭД ЧИГЛҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

6.1. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон концессын эргэн төлөгдөх нөхцөлөөр 32 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад 2025 оноос эхлэн хэрэгжих 108, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 532, нийт 12,421.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 640 ТАХ-г 4,276.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 13. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөгөө /тэрбум төгрөг/

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
<b>Барилга, байгууламж</b>	44	3,885.2	1,110.7	512	7,448.6	2,422.5	556	11,333.8	<b>3,533.2</b>
<b>Их засвар</b>	16	298.7	144.7	6	28.6	10.1	22	327.3	<b>154.9</b>
<b>Тоног төхөөрөмж</b>	40	447.2	447.2	13	218.8	57.4	53	666.1	<b>504.6</b>
<b>ТЭЗҮ</b>	8	94.0	84.0	1	0.25	0.09	9	94.2	<b>84.1</b>
<b>Нийт</b>	<b>108</b>	<b>4,725.1</b>	<b>1,786.7</b>	<b>532</b>	<b>7,696.3</b>	<b>2,490.2</b>	<b>640</b>	<b>12,421.4</b>	<b>4,276.8</b>

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл

6.2. Нийт санхүүжилтийн 91.2 хувийг барилга, байгууламжийн ТАХ, 5.4 хувийг тоног төхөөрөмж, 2.6 хувийг их засвар, 0.8 хувийг ТЭЗҮ боловсруулахад тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

6.3. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын болон концессын эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох 4,276.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг өмнөх оны буюу 2024 онд төлөвлөсөн 3,853.6 тэрбум төгрөгийн санхүүжилттэй харьцуулахад 423.2 тэрбум төгрөгөөр буюу 11 хувиар өссөн бөгөөд барилга байгууламжид төлөвлөсөн санхүүжилт 20.9 хувиар нэмэгдсэн байна.

6.4. Концессын барих-шилжүүлэх төрлөөр “Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 120.9 км /Дархан,

<sup>19</sup> 8.5.1.аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх



Сэлэнгэ, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэр сум/” ТАХ-ний 2025 оны эргэн төлөлтөд 131.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 14. Концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх ТАХ /тэрбум төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 120.85 км /Дархан, Сэлэнгэ, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэр сум /	2024	2027	287.4	131.2

**Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдаагүйгээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зөвхөн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан төлөвлөсөн байна**

6.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг дараах байдлаар уялдуулан төлөвлөхөөр тусгажээ. Үүнд:

- “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг арван жилийн хугацаанд хэрэгжих “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т нийцүүлэн,
- “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн,
- “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тулгуурлан тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөөр,
- Улсын төсөв нь “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд чиглэсэн байхаар тусгажээ.

6.6. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг, 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус баталжээ.

6.7. Засгийн газраас Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг 2024 оны 5 дугаар сарын 01-нд УИХ-д өргөн мэдүүлснийг 08 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцүүлсэн боловч эцэслэн батлагдаагүйгээс 2025 оны төсвийн төлөвлөлтөд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.17<sup>20</sup>, 6.10.3<sup>21</sup>-д заасан “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” алдагдсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

6.8. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3<sup>22</sup>-т заасан чиг үүргийн хүрээнд ЭЗХЯ-аас “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон бусад бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байх тул” гэж ерөнхий байдлаар дүгнэж зөвшөөрөл олгожээ.

<sup>20</sup> 5.2.17. “Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг”

<sup>21</sup> 6.10.3. “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”

<sup>22</sup> 9.4.3. “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг: ... Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх”



6.9. Сангийн яам Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийт 620 зорилт, арга хэмжээнээс 165 арга хэмжээнд хөрөнгө оруулалт шаардлагатай гэж ангилан, түүнээс 44 арга хэмжээний санхүүжилтийг 2025 онд төлөвлөсөн байна.

*Хүснэгт 15. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн уялдаа*

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого зорилт	Төлөвлөсөн арга хэмжээ	Үүнээс	
			Хөрөнгө оруулалт шаардлагатай	2025 онд хөрөнгө оруулалт төлөвлөсөн
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	92	61	15
2	Хүний хөгжлийн бодлого	152	10	5
3	Эдийн засгийн бодлого	222	80	16
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	154	14	8
	<b>Нийт</b>	<b>620</b>	<b>165</b>	<b>44</b>

6.10. Засгийн газраас 2025 онд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бүсүүдийн авто зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийн хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн санхүүжилтийг чиглүүлэн төлөвлөсөн байна.

6.11. Дээрх зорилтын хүрээнд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр эхлүүлэх 108 ТАХ-нд төлөвлөсөн 1,786.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 51.5 хувь буюу 920.4 тэрбум төгрөгийг ЗТС, ЭХС, ХББОСС-ын төсвийн багцад хэрэгжүүлэх авто зам, дэд бүтцийн ТАХ-нд зарцуулахаар тусгажээ.

6.12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний төслийг Бүсчилсэн хөгжлийн болон Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тулгуурлан дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн боловсруулсан байна.

**Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, эрэмбэд суурилан төлөвлөх аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байна**

6.13. Монгол Улсын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд ТЕЗ-даас нийт 2404 арга хэмжээг тусгуулах санал хүргүүлснээс Сангийн яам 783 ТАХ-г үнэлж, үүнээс 640 ТАХ-г улсын төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлжээ.

*Хүснэгт 16. ТЕЗ-аас төсвийн төсөлд хүргүүлсэн болон тусгагдсан ТАХ-ний санал*

№	УТХО-ын төрөл	ТЕЗ нараас хүргүүлсэн санал	Сангийн яамнаас үнэлсэн	Төсвийн төсөлд тусгасан
1	Шинэ ТАХ	1742	783	108
2	Шилжих ТАХ	662	-	532
	<b>Нийт</b>	<b>2404</b>	<b>783</b>	<b>640</b>

*Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл*

6.14. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дүгээр зүйлийн 13.1.223-д заасны дагуу төсвийн төлөвлөлтийг нийт 355 төсөл, арга хэмжээний 75.8 тэрбум төгрөгөөр бууруулан хэмнэлтийн зарчмыг баримталсан байна.

<sup>23</sup> энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох



6.15. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар ТЭЗ нараас санал хүргүүлсэн шинээр эхлүүлэх 1742 ТАХ-ний 783 ТАХ-г буюу 45 хувийг Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ээр үнэлсэн байна.

6.16. ТАХ-ний үнэлгээг харьцуулахад ТЭЗ-аас 80-100 оноогоор үнэлж ирүүлсэн тоног төхөөрөмж, их засвар ангиллын 55 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаагүй байна.


6.17. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 4.324 дах заалтад нийцээгүй байна.

6.18. Дээрх аргачлалд зөвхөн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг хамруулж байгаа нь бусад ангиллын төсөл, арга хэмжээг орхигдуулах, тусгай шалгуур үзүүлэлтээр үнэлээгүй, шаардлага хангаагүй ТАХ-г төсвийн төсөлд тусгах эрсдэлийг дагуулж байна.

6.19. Иймд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмж, их засвар болон ТЭЗҮ-г төлөвлөх, эрэмбэлэх аргачлал, зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна

6.20. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар ТЭЗ нараас хүргүүлсэн шилжих ТАХ-ээс Сангийн яам худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, гүйцэтгэгч шалгараагүй, төсөвт өртөг нэмэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 1,168.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 420.8 тэрбум төгрөгийн шилжих 130 ТАХ-г төсвийн төсөлд тусгаагүй байна.

*Дүрслэл 4. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгаагдаагүй шилжих төсөл, арга хэмжээ*



6.21. Төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаанаар төсвийн төсөлд тусгаагдаагүй 46 шилжих ТАХ-ээс Боловсролын сайд 13 ТАХ-ний өртгийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулан 2025 онд 15.3 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн байна.

6.22. Шилжин хэрэгжих ТАХ-г төсөвт тусгалгүй орхигдуулах нь хэрэгжилт удаашрах, өртөг нэмэгдэх, өмнөх онуудад төсвөөс олгосон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үр ашиг буурах эрсдэлтэй байна.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд багц байдлаар тусгасан төсөл, арга хэмжээний байршил, төсөвт өртгийн задаргааг тусгайлан батлах шаардлагатай байна**

6.23. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсвийн төсөлд 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан 4,725.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 108 шинэ ТАХ-ний 40.7 хувийг барилга

<sup>24</sup> 4.3. “Эрэмбэлэлтийн дараалалд дараах нөхцөл байдлаас бусад тохиолдолд хамгийн өндөр авсан төслийг эхний ээлжид хэрэгжүүлэхээр төсвийн хязгаарт багтаан сонгоно”



байгууламж, 37.0 хувийг тоног төхөөрөмж, 14.8 хувийг их засвар, 7.4 хувийг ТЭЗҮ боловсруулах ТАХ эзэлж байна.

6.24. Шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламж ангиллын 99.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, их засварын ангиллын 298.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээ магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй байна.

6.25. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>25</sup> дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.1<sup>26</sup>, 3.2.2.2<sup>27</sup>, 3.2.3.4<sup>28</sup>-т заасан шаардлагыг хангахгүй байна.

6.26. ТАХ-ний төсөвт өртгийг баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүй төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

6.27. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд 558.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 186.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 ТАХ-ний хэрэгжих байршлыг “бүсүүдэд” болон “улсын хэмжээнд”, “салбарын хөрөнгө оруулалт” зэрэг нэршлээр тодорхой бус байдлаар төлөвлөснийг Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6<sup>29</sup> дахь хэсэгт заасантай нийцүүлэн байршил, төсөвт өртгийг тусгайлан хэлэлцэж батлах шаардлагатай байна.

**Тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг ашиглалтын хугацаа, элэгдлийн зардалтай уялдуулан урсгал зардалд төлөвлөж санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай байна**

6.28. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 182.4 тэрбум төгрөгийн 5 барилгын ажлаас нийт 62.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 барилга байгууламжийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, ажиллах хүч, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгаа, тооцоолол хийгдээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй байна. Үүнд:

- БОУАӨС-ын багцад төлөвлөгдсөн 50.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж /Улаанбаатар/”
- ГХС-ын багцад төлөвлөгдсөн 12.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дипломат корпус” олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/

6.29. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2<sup>30</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.4<sup>31</sup>-д заасан шаардлагад нийцэхгүй байна.

<sup>25</sup> 29.4. “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

<sup>26</sup> 3.2.2.1. “Эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”;

<sup>27</sup> 3.2.2.2. “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх”;

<sup>28</sup> 3.2.3.4. “Тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх”;

<sup>29</sup> 33.2.6. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/ батална”;

<sup>30</sup> 29.2. “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна”

<sup>31</sup> 2.2.4. “Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх”





6.30. ТЭЗ-даас тоног төхөөрөмж ангиллын нийт 317 төсөл, арга хэмжээний 1.6 их наяд төгрөг төлөвлөх санал ирүүлснээс холбогдох 25 ТЭЗ нарын багцад багцалж 40 төсөл, арга хэмжээний 447.3 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна.

6.31. Тоног төхөөрөмж ангиллын ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 4.1.24<sup>32</sup> дэх заалтад нийцүүлж, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай эд зүйл худалдан авдаг байдлыг зогсоож багцын задаргааг тодорхой болгон төлөвлөх шаардлагатай.

6.32. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал” болон “Эдийн засгийн ангиллын тайлбар”-т урсгал зардалд<sup>33</sup> эд хогшлын зардлыг, дэд ангилалд “тавилга”<sup>34</sup>-ыг хамруулахаар баталжээ.

6.33. Цаашид байгууллагын тавилга, эд хогшлыг шинэчлэх, сайжруулах зардлыг ашиглах жил, элэгдлийн зардалтай уялдуулан урсгал зардалд төлөвлөж санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

**Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байна**

6.34. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэг бүр нь 0.8-30.7 тэрбум, нийт 94.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТЭЗҮ боловсруулах ажлыг төлөвлөсөн боловч тухайн ажил бүрийн хүрээнд хийж гүйцэтгүүлэх ажлын даалгавар, тэдгээрийн нэгжийн болон нийт өртгийг тооцсон судалгаа, зардлын тооцоолол, үндэслэл тодорхойгүй байна.

6.35. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.4<sup>35</sup>-д заасан шаардлагад нийцэхгүй байна.

6.36. Нөгөө талаас төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардал, төсвийг тооцож төлөвлөх, хянахад баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авах, хянахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, заавар журам хангалтгүй байгаа нь өртгийг тооцож тодорхойлох, хянахад хүндрэл учруулж байна.

6.37. Иймд цахим систем, ТЭЗҮ боловсруулах ажлын нэгжийн өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоож мөрдүүлэн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хянахад ашиглах шаардлагатай.

**Төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөх шаардлагатай байна**

6.38. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан шинээр эхлүүлэх 108 ТАХ-ээс 36 ТАХ-ний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй буюу 2025 онд ногдох 1,292.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 403.4 тэрбумаар бага 889.2 тэрбумаар төлөвлөжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/ Үүнд:

• ЗТС-ын төсвийн багцад 2025-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 180 км /Зүүн бүс/” ТАХ-ий 324.0 тэрбум төгрөгийн төсөвт

<sup>32</sup> 4.1.24. “төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

<sup>33</sup> “21 Урсгал зардал, 2123 Эд хогшил, 212301 Тавилга”

<sup>34</sup> “Эдийн засгийн ангиллын тайлбар: “Тавилга”-байгууллагын үйл ажиллагаанд зориулж авсан ширээ, сандал, шүүгээ гэх мэт тавилга бэлтгэх зардал”

<sup>35</sup> 3.1.4. “ТЭЗ нь ... төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: ... 3.1.4.4. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх”



өртгөөс жилд ногдох санхүүжилт нь 108.0 тэрбум төгрөг байхад 2025 онд 2.2 дахин бага буюу 48.0 тэрбум төгрөг төлөвлөсөн;

- ЗТС-ын төсвийн багцад 2025-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Дархан-Алтанбулаа чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/” ТАХ-ний 630.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс жилд ногдох санхүүжилт нь 210.2 тэрбум төгрөг байхад 2025 онд 2 дахин бага буюу 104.7 тэрбум төгрөг төлөвлөсөн;

- ЭХС-ын төсвийн багцад 2025-2027 онд буюу 3 жилийн хугацаанд хэрэгжих “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Говь-Алтай/” ТАХ-ний 24.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс жилд ногдох санхүүжилт нь 8.2 тэрбум төгрөг байхад 2025 онд 6.1 тэрбум төгрөг төлөвлөжээ.

6.39. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.5<sup>36</sup>, Төсвийн тухай хуулийн 29.3.5<sup>37</sup> дахь заалтад нийцээгүй байна.

6.40. Гэвч томоохон барилга байгууламжийн ажлын цар хүрээ, төсөвт өртгийн хэмжээ, ажил гүйцэтгэх технологи, дарааллыг харгалзахгүйгээр 3 жилийн дотор хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

6.41. Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;” гэж заасан нь олон жил үргэлжлэх томоохон төсөл, арга хэмжээний хувьд тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй эрсдэл үүсгэж байна.

**Өмнөх аудитаар ТЕЗ нарт өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжилт хангалтгүй байна**

6.42. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд дүгнэлт гаргах аудитын хүрээнд нийт 9,121.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1049 хөрөнгө оруулалтын ТАХ нь Төсвийн тухай хуулийн болон холбогдох бусад хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт өгч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 2 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

6.43. Улсын төсвийн 2024 оны төсвийн төсөлд нэг маягийн зураг төсөлтэй, инженерийн шугам сүлжээний холболтын зураг төсөвгүй 153, зураг төслийг боловсруулж баталгаажуулаагүй 21, нийт 174 ТАХ-г тусгасан зөрчил илэрснийг арилгуулахаар Сангийн сайдад 1 албан шаардлага хүргүүлснээс 155 нь хэрэгжиж 89.1 хувьтай биелжээ.

6.44. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол болон хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцооллыг хийгээгүй зөрчлүүдийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлагын биелэлт хангагдсан байна.

6.45. Дээрх 2 албан шаардлагад аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж биелэлтийг ирүүлэхээс гадна цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасан бөгөөд өмнө онтой харьцуулахад зөрчлийн тоо хэмжээ буурсан байна.

6.46. Өмнөх аудитаар Сангийн сайд болон Эдийн засаг хөгжлийн сайдад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлттэй холбоотой 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж нь хэрэгжээгүй, 2 зөвлөмжийг 65 хувьтай хэрэгжүүлжээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хүлээн авах үйл ажиллагаанд хүнээс хамаарсан нөлөөллийг бууруулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй;

<sup>36</sup> 17.1.5. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх”

<sup>37</sup> 29.3.5. “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”



- “Төсөвт өртгийн нэмэгдэл зардал гарч байгаа шалтгаан нөхцөлд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, үр дүнг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах” болон “Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах” гэсэн 2 зөвлөмжийн хэрэгжилт 65 хувьтай байна.

**ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙГ НЭРЛЭСЭН ДҮНГЭЭР 40,493.0 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР ТООЦСОН НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙНА.**

7.1. Улсын Их Хурлаас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 6 дугаар зүйлийн 6.1.4-т оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийг нэрлэсэн дүнгээр тооцохоор баталсан байна.

7.2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд өрийн үлдэгдлийг нэрлэсэн дүнгээр тооцож 40,493.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дотоод үнэт цаас 426.7 тэрбум төгрөг, гадаад үнэт цаас 8,998.3 тэрбум төгрөг, гадаад зээл 24,464.8 тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн баталгаа 5,792.2 тэрбум төгрөг, орон нутгийн зээллэг 811.0 тэрбум төгрөг байхаар тусгасан байна.

Хүснэгт 17. Засгийн газрын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2023 оны гүйц.	2024 оны	2025 оны	Зөрүү /+нэмэгдсэн, -хасагдсан/	
		ХБГ	Төсөв	2023 оноос	2024 ХБГ-с
Засгийн газрын дотоод өр	234.1	437.3	426.7	192.6	(10.6)
Дотоод үнэт цаас	234.1	437.3	426.7	192.6	(10.6)
Засгийн газрын гадаад өр	30,274.6	31,772.4	33,463.1	3,188.5	1,690.7
Гадаад үнэт цаас	9,371.7	9,086.1	8,998.3	(373.4)	(87.8)
Гадаад зээл	20,902.9	22,686.3	24,464.8	3,561.9	1,778.5
Засгийн газрын бусад өр	264.8	2,996.4	6,603.2	6,338.4	3,606.8
Засгийн газрын өрийн баталгаа	29.5	1,985.4	5,792.2	5,762.7	3,806.8
Орон нутгийн өр	4.5	1,011.0	811.0	806.5	(200.0)
Барих-шилжүүлэх концесс**	230.9	-	-		
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР	30,773.5	35,206.2	40,493.0	9,719.5	5,286.8
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	26,582.9	30,658.0	35,588.3	9,005.4	4,930.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	65.0%	60.0%*	60.0%*		
Засгийн газрын өр/ ДНБ	44.7%	44.4%	42.6%	-2.1%	-1.8%
Засгийн газрын өр(ӨҮЦ)/ ДНБ	38.6%			-38.6%	0.0%


Эх сурвалж: Сангийн яам /\*-Нэрлэсэн дүнгээр тооцсон \*\*- Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дахь хэсэг хүчингүй болсон/

7.3. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 44.4 хувьтай, 2025 оны төсөөллөөр 42.6 хувьтай буюу хуулийн тусгай шаардлагыг хангаж байна.

7.4. Засгийн газрын өрийн хэмжээ нэрлэсэн дүнгээр нэмэгдэж байгаа боловч Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2016 онд 93.1 хувьтай тэнцэж байсан бол 2023 онд 44.7 хувь болж, өрийн дарамт буурсан байна.



Дүрслэл 5. Засгийн газрын өрийн харьцуулалт



Эх сурвалж: Сангийн яам

7.5. Засгийн газрын өр 2010-2025 онуудад жилд дунджаар 2,527.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

7.6. Төсвийн төслийн 2025 оны өрийн үлдэгдлийг өмнөх оны дүнтэй харьцуулахад дотоод үнэт цаас 10.6 тэрбум төгрөгөөр орон нутгийн зээллэг 204.0 тэрбум төгрөгөөр буурахаар байгаа бол гадаад өр 1,690.7 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын өрийн баталгаа 3,806.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулахад зориулж Нийслэлийн Засаг даргын тамгын газраас орон нутгийн бонд гаргах, гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэхээр төлөвлөсөн;
- Засгийн газрын өрийн баталгаа 3,500.0 тэрбум гаргах, ханшийн зөрүү 336.0 тэрбум төгрөг нийт 3,836.0 тэрбум төгрөгөөр өсөхөөр байгаа нь “Хөшгийн хөндийн туннел” болон “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн төсөлд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар төлөвлөсөнтэй холбоотой байна. Энэхүү төслүүдийн бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд дууссан тохиолдолд УИХ, УАГ-т дахин танилцуулж шийдвэр гаргуулахаар төлөвлөсөн;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг нэгдсэн төсвийн суурь тэнцлээс төлж барагдуулахаар төлөвлөсөн тул төсвийн дэмжлэгийн хүрээнд шинээр өр үүсгэхээргүй байгаа бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын хэмжээг 2,209.2 тэрбум төгрөг, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, төлбөрийн тэнцлийг дэмжих зэрэг зорилгоор 300.0 тэрбум төгрөгийн зээллэг хийхээр төлөвлөжээ;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу ДНБ-ний 2 хувьтай тэнцэх нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ашиг 1,909.5 тэрбум төгрөгөөр Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлөхөөр байгаа тул гадаад зээл, дотоод үнэт цаас, нийслэлийн үнэт цаасыг төлж барагдуулснаас үлдсэн хэсгээр өрийн зохицуулалтын арга хэмжээ буюу буцаан худалдан авах үйл ажиллагааг эхлүүлж, Засгийн газрын өрийн дарамтыг бууруулахаар төлөвлөжээ.

7.7. Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 3,008.9 тэрбум төгрөгийг 2025 онд төлөхөөр тооцсон байна.



Хүснэгт 18. Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр /тэрбум төгрөг/

Өрийн үйлчилгээ	2023 он	2024 оны ХБГ	2025 оны төс.
<b>Үндсэн төлбөр</b>	<b>2,152.6</b>	<b>1,545.9</b>	<b>1,705.5</b>
Гадаад бонд*	391.4	178.5	243.1
Гадаад зээл	959.8	1,229.9	1,454.9
Дотоод бонд	801.4	137.5	7.5
<b>Хүүгийн төлбөр</b>	<b>1,092.6</b>	<b>1,173.6</b>	<b>1,303.4</b>
Гадаад бонд	553.0	556.2	576.8
Гадаад зээл	459.9	610.0	681.4
Дотоод бонд	79.7	7.5	45.2
<b>НИЙТ</b>	<b>3,243.3</b>	<b>2,719.5</b>	<b>3,008.9</b>

Эх сурвалж: Сангийн яам

\*-Дахин санхүүжилтийн дүн ороогүй

7.8. Гадаад зээлийн гэрээ нь байгуулагдан хэрэгжиж буй төсөл арга хэмжээний ашиглаагүй үлдэгдэл 2024 оны 07 дугаар сарын 25-ны байдлаар 11,956.3 тэрбум төгрөг байгаа ч 2025 онд 2,209.0 тэрбум төгрөгийг буюу 18.5 хувийг ашиглахаар төлөвлөснөөс үзэхэд дунд хугацаанд ирэх төсвийн ачаалал ирэх онуудад өндөр байх, төсөл арга хэмжээнд төлөвлөгдөж буй эх үүсвэр хангалттай бус байгаа нь төслийн үр ашигтай хэрэгжилт болон төслийн хэрэгжих хугацаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

7.9. Тухайлбал, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2025 оны гадаадын зээлээр хэрэгжүүлэх төслийн саналд нийт 5,982.5 тэрбум төгрөгийн санал ирүүлсэн ч 2,209.0 тэрбум төгрөг нь буюу 36.9 хувь нь төсөвт тусгагджээ. Энэ нь төслийн хэрэгжих хугацаа зээлийн гэрээнд заасан хугацаагаар уртсах, өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.

7.10. Иймд зээл, тусламжийн төслүүдийн санхүүжилтийг бодитоор төсөвт тусгах замаар цаг хугацаанд нь үр ашигтай дуусгах чиглэлээр Сангийн яам, холбогдох төсөл хэрэгжүүлэгч яамд, байгууллагууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

7.11. Монгол улсын 2025 онд төсвийн төсөлд гадаад зээлээр 2,209.0 тэрбум төгрөг ашиглахаар тооцсоноос 2,192.3 тэрбум төгрөгийг ашиглаж зарцуулах арга хэмжээ, хөтөлбөр нь тодорхой, 16.6 тэрбум төгрөг зээлийн зарцуулалт тодорхой бус байна.

7.12. Шинээр ашиглахаар тооцсон зээлийн ашиглалтыг өрийн удирдлагын тухай хуульд заасан шалгуурт бүрэн нийцүүлэх, Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, ашиглагдаагүй зээлийн хэмжээг хязгаарлах, гадаад зээлийн гэрээ хэлэлцээр байгуулахаас өмнөх төслийн бэлтгэл ажлыг шуурхай хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

## НАЙМ. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАЖ БАЙНА

8.1. Төсвийн төсөлд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 33,864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлагын хэмжээг 35,795.2 тэрбум төгрөг буюу 37.7 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү байхаар төлөвлөжээ.

Хүснэгт 19. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2025 төсөл
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>36,830.4</b>
Тогтворжуулалтын сан	608.9
Үндэсний баялгийн сан	2,356.8
Ирээдүй өв сан	1,849.7
Хуримтлалын сан	507.1



<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО</b>	<b>33,864.7</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>35,795.2</b>
Урсгал зардал	26,036.4
Хөрөнгийн зардал	9,803.8
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-45.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ</b>	<b>-1,930.5</b>
ДНБ-д эзлэх хувь	-2.0
<b>ҮНЭТ ЦААСААР САНХҮҮЖИХ ДҮН</b>	<b>1,631.0*</b>
<b>ГАДААД ЗЭЭЛЭЭР САНХҮҮЖИХ ДҮН</b>	<b>2,209.0*</b>
<b>СУУРЬ ЗАРЛАГА</b>	<b>31,955.2*</b>
ДНБ-д эзлэх хувь	33.8
<b>СУУРЬ ТЭНЦЭЛ</b>	<b>1,909.5</b>
ДНБ-д эзлэх хувь	2.0

Эх сурвалж: Сангийн яам /\*Хуулийн төслийн тооцоолол/

8.2. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 33,864.7 тэрбум төгрөг, суурь зарлагын дүнг 31,955.2 тэрбум төгрөг байхаар тус тус төлөвлөжээ.

8.3. Өмнөх оноос нийт орлогыг 6,190.9 тэрбум төгрөг буюу 20.2 хувиар, нийт зарлагыг 5,307.3 тэрбум төгрөг буюу 17.4 хувиар нэмж төлөвлөсөн байна.

8.4. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,909.5 тэрбум төгрөгийн ашигтай байгаа нь ДНБ-ийн 95,010.0 тэрбум төгрөгийн 2.0 хувьтай тэнцэж байна.

## ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 69.0 ХУВЬ БАЙНА

1. Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

2. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

Хүснэгт 20. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн мэдээ

№	Хэнд өгсөн	Нийт	Үүнээс биелэлт ирүүлсэн
<b>Албан шаардлага</b>			
1	Сангийн яам	2	2
<b>Зөвлөмж</b>			
1	Улсын Их Хурал	2	0
2	Засгийн газар	5	4
3	Сангийн яам	4	4
4	Эдийн засаг, хөгжлийн яам	2	2
5	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	2	0

3. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар Сангийн яаманд 2 албан шаардлага, 4 зөвлөмж, УИХ-д 2, Засгийн газарт 4, ЭЗХЯ-нд 2, төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2, нийт 2 албан шаардлага, 15 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 2 албан шаардлага, 10 зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т ирүүлсэн байна. Биелэлтийг ирүүлсэн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг үнэлэхэд дунджаар 69.0 хувийн биелэлттэй байна.



## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33,864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлагын хэмжээг 35,795.2 тэрбум төгрөг буюу 37.7 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байна.
2. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн ба Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.
3. Төсвийн төслийн хамт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдаагүйгээс Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.
5. Төсвийн боломжит эх үүсвэр, бүх төрлийн ашигт малтмалд ногдуулсан АМНАТ-ыг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.
6. Гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг хэрхэн санхүүжүүлэх, орлогыг нөхөх эрсдэлийг тооцох шаардлагатай байна.
7. Засгийн газраас 2025 онд бүсчилсэн хөгжлийн хүрээнд дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилт дэвшүүлэн авто зам, эрчим хүч, дэд бүтцийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь өмнөх онуудад улс, бүсийн түвшинд тэргүүлэх ач холбогдол багатай, олон жижиг төсөл, арга хэмжээг улсын төсвөөр санхүүжүүлэхээр тусгаж байсантай харьцуулахад төсөл, арга хэмжээний цар хүрээ, үр нөлөөний хувьд тодорхой ахиц гарсан байна.
8. Төсвийн ерөнхийлөн захирагч нар шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан холбогдох хууль, журмын дагуу бүрэн, үнэн зөв үнэлж эрэмбэлж төлөвлөх шаардлагатай байна.
9. Шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалд зөвхөн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг хамруулж байгаа нь бусад ангиллын төсөл, арга хэмжээг орхигдуулах, тусгай шалгуур үзүүлэлтээр үнэлээгүй, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах эрсдэлийг дагуулж байна.
10. Өмнө оноос шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, гүйцэтгэгч шалгараагүй, төсөвт өртөг нэмэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 1,168.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 420.8 тэрбум төгрөгийн 130 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаагүй байна.
11. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр 3 жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээний төсөв батлагдахгүй орхигдох эрсдэлийг үүсгэж байна.
12. Төсөл, арга хэмжээний байршлыг “бүсүүдэд” болон “улсын хэмжээнд”, “салбарын хөрөнгө оруулалт” зэрэг нэршлээр тодорхой бус байдлаар төлөвлөснийг байршил, төсөвт өртгийг тусгайлан хэлэлцэж батлах шаардлагатай байна.



13. Байгууллагын тавилга, эд хогшлыг шинэчлэх зардлыг ашиглалтын хугацаа, элэгдэлтэй уялдуулан урсгал зардалд төлөвлөж санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай байна.
14. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.
15. Өмнөх аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах зөрчил өмнө онтой харьцуулахад буурсан боловч дахин давтагдсан байна.





## **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

### **Улсын Их Хуралд толилуулах:**

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг жилийн төсвийн төслийг боловсруулахаас өмнө баталж байх;
2. Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх.

### **Монгол Улсын Засгийн газарт:**

1. Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чанарыг дээшлүүлж, төсвийн сахилга батыг хангаж ажиллах;
2. Төсвийн төслийг төрийн мөнгөний бодлогод нийцүүлэх, төсвийн зардлын тэлэлтээс нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг үр дагаврыг үнэлж, бууруулах арга хэмжээ авах;
3. Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг төсвийн төлөвлөлтийн болон эрх зүйн шаардлагыг хангуулах;
4. Төсвийн боломжит эх үүсвэр, бүх төрлийн ашигт малтмалд ногдуулсан АМНАТ-ыг бүрэн төвлөрүүлэх;
5. Хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, төлөвлөсөн хугацаанд, чанартай гүйцэтгэхэд хяналтыг хэрэгжүүлэн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;
6. Геополитикийн тогтворгүй байдлын улмаас авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй тул шаардлагатай стратегийн нөөц бүрдүүлэхэд анхаарах;
7. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “бүсүүдэд”, “улсын хэмжээнд”, “салбарын хөрөнгө оруулалт” зэргээр байршил тодорхойгүй тусгагдсан арга хэмжээний задаргааг тусгайлан хэлэлцүүлж батлуулах;
8. Өмнөх онуудад хэрэгжиж эхэлсэн, дуусаагүй боловч төсвийн төсөлд тусгаагүй төсөл, арга хэмжээний үр ашигт анхаарч, холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлэх.

### **Сангийн сайдад:**

1. УИХ-аас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх;
2. Төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх;
3. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төрөл, ангиллаар нарийвчлан тодорхойлж хууль, журамд тусгах;
4. Тоног төхөөрөмж, их засвар болон ТЭЗҮ-г төлөвлөх, эрэмбэлэх аргачлал, зохицуулалтыг тодорхой болгох.



**Монгол улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдад:**

1. Цахим систем нэршлээр төсвийн төсөлд тусгасан төсөл, арга хэмжээ болон техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох.

**Төсвийн ерөнхийлөн захирагчдад:**

1. Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэн, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх;



## Хавсралтууд

Шалгагдагч этгээдээс тайлангийн төсөлд санал авахаар хүргүүлсэн бичиг



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ  
ТАНАА

2024.09.20 № 01/1895  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тайлангийн төслийг хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн төслийг Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн төслийг шалгагдагч этгээдэд хүргүүлнэ" гэж заасны дагуу санал авахаар хүргүүлж байна.

Хавсралт .... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГ



Я.САМБУУНЯМ



Шалгагдагч этгээдээс тайлангийн төсөлд ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.09.28 № 03/7896

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хүсэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлттэй танилцаад дүгнэлттэй холбоотой асуудлуудад нэмэлт тайлбар болон өөрчлөх саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Дүгнэлтийн 2.1-т Төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ гэж заасан байхад эрсдэлийн тойм мэдээг ирүүлсэн, ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр ирүүлсэн боловч тэдгээртэй холбогдсон тайлбар танилцуулга бүрэн бус, санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар ирүүлээгүй, мөн төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөллийг ирүүлээгүй гэж тус, тус тусгасан байна.

Тайлбар: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад нийт 1299 төсөл, арга хэмжээ батлагдсанаас тухайн онд шинээр хэрэгжүүлэх 691 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахаар заасан. Энэ хүрээнд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгагдсан боловч 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар худалдан авах ажиллагаа зарлаагүй нийт 243,432.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 98,725.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 41 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслөөс хасаж өргөн мэдүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу дээрх 41 төсөл арга хэмжээг төсвийн тухай хуулиас хассанаар Монгол Улсын 2025 оны төсөвт Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан зам, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүдийг төсөвт тусгах, санхүүжүүлэх боломж бүрдэж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.5-т Төсвийн төслийн танилцуулгад төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл тусгана гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгын 30 дугаар хуудас дээр татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөллийг тусгасан байгаа болно.

9766014909



Иймд Дүгнэлтийн 2.1-т заасан заалтыг хасах саналтай байна.

2. Дүгнэлтийн 4.5-д заасан Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг заасан хүснэгтэд Эх сурвалж дээр Эдийн засгийн хөгжлийн яам гэж нэмэх;

3. Дүгнэлтийн 4.7-д заасан Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн харьцуулалт заасан хүснэгтэд Эх сурвалж дээр Эдийн засгийн хөгжлийн яам, Үндэсний аудитын газар гэж нэмэх;

4. Дүгнэлтийн 4.16-д татварын бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулж төлөвлөөгүйгээс навигацийн болон ногдол ашгийн орлого тасарч болзошгүй гэж тусгасан байна.

Тайлбар: Энэ оны 8 сарын байдлаар олон улсын дамжин өнгөрөлтийн нислэгийн тоо 43,022 хүрч, өмнөх оны мөн үеэс 69 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иймд энэ оны өнгөрөлтийн нислэгийн гүйцэтгэлийг харгалзан ирэх онд 80 тэрбум төгрөгийн навигацийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон болно.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг ирэх жил үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ. Улмаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд үндэслэн ирэх онд ногдол ашгийн орлогоор төсөвт 607 тэрбум төвлөрүүлэхээр тооцсон болно.

5. Дүгнэлтийн 5.10-т заасан Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад Улсын хоёрдугаар төв эмнэлгийн өндөр өртөгтэй 2021 оны 10 сард ашиглалтад орсон мэргэжлийн тоног төхөөрөмж "РЭТ/СТ"-ийн засвар үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөг төсөвлөсөн ч шаардлагатай сэлбэгийн жагсаалт, баталгааны хуудас зэрэг нотлох баримт байхгүй гэж тусгасан байна.

Тайлбар: Эрүүл мэнд, спортын яам, Самсунг С&Т корпораци хооронд "Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн зураг төсөл, барилгын ажил, худалдан авалт, эмнэлгийн тоног төхөөрөмж болон эмнэлгийн мэдээллийн систем/зайн оношилгооны тоног төхөөрөмжийн ажлыг гүйцэтгүүлэхээр/ гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг 2015 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр А/644 дүгээр "Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай" тушаалаар Улсын хоёрдугаар төв эмнэлэгт 67.2 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг шилжүүлж, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Самсунг С&Т корпораци бүрэн хүлээлгэн өгсөн актыг Эрүүл мэндийн яамтай үйлдсэн байна. Гэрээний тусгай нөхцөлийн 11.12-д Гэмтэл доголдлыг арилгах зардал хэсэгт "Захиалагч ашиглалтад оруулах актыг олгосон өдрөөс хойш барилгын гэмтэл доголдлыг арилгах хугацааг 36 сар, Эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн мэдээллийн систем/зайн оношилгооны гэмтэл доголдлыг арилгах хугацаа 24 сар гэж заасан. Үндэсний оношлогоо эмчилгээний төвийн ПЭТ/СТ нь хавдрын оношлогоо, хавдрын үе шат тогтоох, эмчилгээний үр дүнг үнэлж, хавдрын дахилтыг илрүүлдэг, улсын хэмжээнд ганцхан байдаг аппарат бөгөөд 2024 оноос энэхүү аппаратын баталгаат засварын хугацаа дууссан тул Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь цаашид засвар үйлчилгээг бүрэн хариуцана. Иймд энэхүү



оношилгооны аппаратын баталгаат засвар үйлчилгээг балансын дүнгээс 3 хувиар тооцож 2.0 тэрбум төгрөгийг 2025 оны төсвийн төслийн саналд тусгасан болно.

Иймд Дүгнэлтийн 5.10-т заасан заалтыг хасах саналтай байна.

6. Дүгнэлтийн 5.15-д Хууль зүй, дотоод хэргийн сайдын орон тоог Засгийн газрын тогтоол, шийдвэр гараагүй байхад 1,149-өөр, цалингийн санг 34.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн гэж заасан байна.

Тайлбар: Үндэсний аудитын газрын тайланд тусгагдсан 1,149 орон тоо нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяа Цагдаагийн ерөнхий газрын 1,042 орон тоо, Дотоод хэргийн их сургуулийн 107 орон тоо, нийт 1,149 орон тоо байна. Үүнийг 2025 оны төсвийн төсөлд тусгасан хууль, эрх зүйн үндэслэлийг тайлбарлавал: 1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.1, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.3.2.5-д “Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршил ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, 2. Засгийн газрын 2017 оны 281, 2023 оны 126, 141, 2024 оны 35 дугаар тогтоолын дагуу шинээр нэмэгдсэн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх байр, Улаанбаатар хотын Ус хангамжийн эх үүсвэрийн Яармаг насос, Чингэлтэй насос, Хайлааст насос, Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийн 16 гүний худаг, 1 усан сан, Мөрөн хотын ус хангамжийн эх үүсвэрийн 4 гүний худаг, 2 усан сан, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн 4 гүний худаг, 1 усан сан, Ховд хотын ус хангамжийн эх үүсвэрийн усан санг дотоодын цэргийн хамгаалалтад авах, 3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3.7.8-д “Гэрч, хохирогчийг хамгаалах, тусгай албан тушаалтны гэмт хэргийг хянан шалгах алба шинээр байгуулна” гэж, 4. Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэж шинээр заасантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газарт гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардагдах орон тоо, 5. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бүтцийг бий болгон, чадавхыг бэхжүүлэх” зорилт тусгагдсан, мөн Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэлийн 3 дахь заалтаар “Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн нэгж байгуулах, 6. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ын 1.10-д хэсгийн байцаагч 4000 хүн ам тутамд ажиллахаар заасан, мөн Нийслэлийн дүүргүүдийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж зарим хороодыг хуваан шинээр 33 хороо нэмэгдсэнтэй холбоотойгоор албан ажлын ачаалал хэтэрсэн байгааг харгалзан, 7. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн орчинд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл ажиллуулна.” гэж заасантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, төрийн тусгай хамгаалалтад байдаг төрийн өндөр албан тушаалтнуудын хамгаалалт болон Монгол Улсад айлчлах гадаад улсын төрийн тэргүүн, өндөр дээд



хэмжээний зочид, төлөөлөгчдийн хамгаалалт, төрийн ёслолын үйл ажиллагаанд мотоциклтой хамгаалалт ашиглах, хамгаалалтад ажиллах алба хаагчдын тусгай нэгж байгуулах, 8. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны А/116/65 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын 3.9.11 дэх хэсэгт зааснаар "Шүүх хуралдаан бүрд хамгаалалтын цагдаа үүрэг гүйцэтгэх" гэж заасны дагуу Цагдаагийн хамгаалалтад авах, 9. Засгийн газрын 2013 оны 267 дугаар тогтоолоор Хууль сахиулах их сургуулийн харьяа Ахлагчийн сургууль, Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяанд "Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв" нэртэйгээр өөрчлөн байгуулсан. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байхаар заасан. Энэ хуулийн дагуу Ахлагч Мэргэжил сургалт-үйлдвэрийн төвийг хуультай нийцүүлэх шаардлага үүссэн.

Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Дотоод хэргийн их сургуульд 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 11/592 дугаар албан бичгээр "...хуулийн этгээдийн улсын бүртгэлд мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв гэх нэршилтэй байгаа Төрийн болон хувийн өмчийн сургалтын байгууллагууд мэргэжлийн боловсролын сургууль болгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах" гэсэн чиглэлийг хүргүүлсэн байна.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсролын сургууль байна" гэж заасны дагуу "Ахлагч" бүрэлдэхүүнд мэргэжлийн боловсрол олгох хүрээнд "Ахлагч" мэргэжлийн боловсролын сургууль болгон, 1 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан орон тоог нэмэгдүүлсэн.

Иймд Дүгнэлтийн 5.15-д заасан заалтыг хасах саналтай байна.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ



Хавсралт 1. Төсвийн урсгал зардал, эдийн засгийн ангиллаар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 оны төсөв	2025 Хязгаар	2025 ТЕЗ санал	2025 УИХ өргөн мэдүүлсэн	Өмнөх оноос өссөн	Хувь
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,405.6	5,550.3	7,984.1	6,564.2	1,158.6	21
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	538.6	559.0	718.1	659.8	121.2	22
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	577.2	547.4	731.9	863.3	286.1	50
Хангамж, бараа материалын зардал	206.3	203.8	456.1	281.6	75.3	37
Нормативт зардал	360.0	326.3	629.1	498.0	138.1	38
Эд хогшил, урсгал засварын зардал	158.5	137.3	386.8	267.9	109.4	69
Томиллолт, зочны зардал	76.7	59.4	151.8	111.7	35.0	46
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,497.0	4,128.7	3,480.9	1,989.0	492.0	33
Бараа үйлчилгээний бусад зардал	936.2	793.1	1,597.3	1,012.8	76.7	8
Хүү	1,204.8	1,197.2	1,655.3	1,331.6	126.8	11
Татаас	2,079.3	1,798.0	3,699.0	2,566.2	486.9	23
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,674.4	6,328.9	5,983.3	6,893.0	1,218.6	21
Бусад урсгал шилжүүлэг	9,051.7	8,343.4	10,236.1	9,498.7	447.0	5
<b>Дүн</b>	<b>27,766.1</b>	<b>29,973.0</b>	<b>37,709.8</b>	<b>26,036.4</b>	<b>4,771.6</b>	<b>17</b>

Эх сурвалж: Сангийн яам





Хавсралт 2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан зарим төсөл, арга хэмжээний 2025 онд ногдох санхүүжилтийг төлөвлөсөн байдал

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төлөвлөсөн төсөвт өртөг	Нэг жилд ногдох санхүүжилт	2025 онд төлөвлөсөн санхүүжилт	Тухайн жилд дутуу төлөвлөсөн санхүүжилт	
								Мөнгөн дүн	Хувь
1	Зам, тээврийн сайд	Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 180 км /Зүүн бүс/	2025	2027	324.0	108.0	48.0	60.0	56%
2	Зам, тээврийн сайд	Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 км /Зүүн бүс/	2025	2027	460.8	153.6	75.0	78.6	51%
3	Зам, тээврийн сайд	Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 км, гүүрэн байгууламж, 885.6 у/м /Төвийн бүс/	2025	2027	630.6	210.2	104.6	105.5	50%
4	Зам, тээврийн сайд	Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 159.5 км /Баруун бүс/	2025	2027	199.4	66.5	39.9	26.6	40%
5	Зам, тээврийн сайд	Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/	2025	2027	163.7	54.6	32.7	21.8	40%
6	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Говь-Алтай/	2025	2027	24.5	8.2	6.1	2.0	25%
7	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Өнөр бүл-Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамжийн газар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2025	2027	23.9	8.0	6.0	2.0	25%
8	Зам, тээврийн сайд	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 59.2 км /Хойд бүс/	2025	2027	103.6	34.5	25.9	8.6	25%
9	Зам, тээврийн сайд	Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/	2025	2027	98.0	32.7	24.5	8.2	25%



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

10	Зам, тээврийн сайд	Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх шинэчлэл, 6 гүүрэн байгууламж хамт /Улаанбаатар/	2025	2027	222.0	74.0	55.5	18.5	25%
11	Зам, тээврийн сайд	Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/	2025	2027	44.9	15.0	11.2	3.7	25%
12	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Завхан, Улиастай сум/	2025	2027	19.8	6.6	4.9	1.6	25%
13	Зам, тээврийн сайд	Багануур тойрог авто зам, 14.4 км /Багануур хот/	2025	2027	46.2	15.4	11.8	3.5	23%
14	Эрчим хүчний сайд	Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/	2025	2026	59.9	29.9	23.9	6.0	20%
15	Зам, тээврийн сайд	Солонготын давааны хатуу хучилттай авто зам, 12.08 км /Баруун бүс/	2025	2026	46.3	23.1	18.5	4.6	20%
16	Зам, тээврийн сайд	Өгийннуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/	2025	2026	45.0	22.5	18.0	4.5	20%
17	Зам, тээврийн сайд	Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/	2025	2026	41.1	20.5	16.4	4.1	20%
18	Зам, тээврийн сайд	Хэрээтийн давааны хэсгийн 35.5 км хайрган хучилттай авто зам, Түнэл сумаас Чандмань-Өндөр сум чиглэлийн авто замын Бийжийн даваа, Бор бургасын давааны хэсгийн 9 км хайрган хучилттай авто зам /Хойд бүс/	2025	2026	15.1	7.6	6.1	1.5	20%
19	Эрүүл мэндийн сайд	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2025	2026	24.9	12.4	9.9	2.5	20%
20	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Төв/	2025	2026	3.9	2.0	1.6	0.4	20%
21	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2025	2026	4.2	2.1	1.7	0.4	20%
22	Зам, тээврийн сайд	Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/	2025	2027	160.5	53.5	48.2	5.4	10%



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

23	Зам, тээврийн сайд	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Батцэнгэл-Их тамир сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 67 км /Хангайн бүс/	2025	2027	122.5	40.8	36.8	4.1	10%
24	Зам, тээврийн сайд	Аялал жуулчлалын Норовлин-Дадал чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54 км /Зүүн бүс/	2025	2027	49.3	16.4	14.8	1.6	10%
25	Гадаад харилцааны сайд	"Дипломат корпус" олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв /Улаанбаатар/	2025	2027	12.0	4.0	3.6	0.4	10%
26	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/	2025	2027	16.3	5.4	4.9	0.5	10%
27	Зам, тээврийн сайд	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын дуусгал, 74.2 км /Говийн бүс/	2025	2027	160.1	53.4	48.0	5.3	10%
28	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/	2025	2027	213.2	71.1	64.0	7.1	10%
29	зам, тээврийн сайд	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Мандалговь-Чойр чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 2 дугаар үе шат /Говийн бүс/	2025	2027	89.7	29.9	26.9	3.0	10%
30	Зам, тээврийн сайд	Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/	2025	2027	118.4	39.5	35.5	3.9	10%
31	Эрчим хүчний сайд	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Өвөрхангай/	2025	2027	19.1	6.4	5.7	0.6	10%
32	Эрчим хүчний сайд	Налайх Дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2025	2027	56.4	18.8	16.9	1.9	10%
33	Зам, тээврийн сайд	A0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хоорондох	2025	2027	38.1	12.7	11.4	1.3	10%



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

		27 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлт /Зүүн бүс/								
34	Эрчим хүчний сайд	"Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төслийн үргэлжлэл /Шинэ Зуунмод хотын 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, 110/35/10 кВ дэд станцын барилга угсралтын ажлын үргэлжлэл /Төв, Сэргэлэн сум/	2025	2027	25.9	8.6	7.8	0.9	10%	
35	Зам, тээврийн сайд	Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх 45.2 км хатуу хучилттай авто зам, Түнхэл тосгон доторх 4 км хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/	2025	2027	52.4	17.5	15.7	1.7	10%	
36	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ /Төв, Сэргэлэн сум/	2025	2027	22.0	7.3	6.6	0.7	10%	



Хавсралт 3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

Өгсөн зөвлөмж	Ирүүлсэн биелэлт	Үнэлгээ
<b>Монгол Улсын Засгийн газар</b>		
<p>Дунд ба урт хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулж, төсөвт үзүүлэх гадаад өрийн ачааллыг бууруулж төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг хэрэгжүүлж, төсвийн алдагдлыг 2 хувиас бага байлгах эдийн засгийн зохист харьцааг хангаж ажиллах.</p>	<p>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2021 онд ДНБ-ий 6.7 хувь, 2022 онд 1.9 хувь байсан бол 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарч ДНБ-ий 1.3 хувьд хүрсэн. Хуульд заасны дагуу 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг ДНБ-ий 2 хувь байхаар төлөвлөн батлуулсан бөгөөд энэ нь хуульд заасан шаардлагаас бага үзүүлэлт болно. Ийнхүү төсвийн алдагдлыг бууруулж байгаа нь Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулахад хамгийн том хүчин зүйл болж, Засгийн газрын өр нэмэгдүүлэх хэмжээг бууруулж байгаа болно.</p>	100
<p>“Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабрын дагуу 2024 оны 7 дугаар сарын 25-ны дотор Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулах төсөл арга хэмжээний саналыг ТЕЗ-даас Сангийн яаманд ирүүлээд байна. Уг саналуудыг нэгтгэн өмнөх онуудад тусгагдан хэрэгжиж буй төсөвт өртгийн нэмэгдэлтэй төсөл, арга хэмжээний мэдээллийг судлан, холбогдох дүн шинжилгээг хийж байна. Түүнчлэн УТХО-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх хэд, хэдэн хүчин зүйл байгаа бөгөөд 2023 онд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан төслүүдийн дийлэнх хувь нь захиалагч, захиалагчийн хяналтын байгууллагуудын буруутай үйл ажиллагаанаас үүдсэн байна. Тухайлбал, тендер шалгаруулалтад ажлын тоо хэмжээг хасаж зарлах, зураг төслийн зохиогч байгууллагуудад тавих хяналт сул, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул зэргээс хамаарч ТАХ удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх нөхцөл байдал үүсч байна. Мөн нэг томоохон хүчин зүйл нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, ТАХ-ний төсөв зохиох, норм, нормативыг шинэчлэх, хэрэгжүүлэх ажил нь удаашралтай байгаа явдал юм. Энэ нь өнөөгийн зах зээлийн нийгэмд зохицохгүй, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тооцоололтой байгаагаас материалын үнэ болон цалингийн өсөлтөд байнга нэрвэгдэж, төсөвт өртөг нэмэгдэх суурь нөхцөл болж байна. Уг асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Сангийн яамнаас ТЕЗ, аймаг, нийслэлийн ЗД нар, БХТ, ЗТХТ, ЭХҮТ, болон холбогдох хяналтын байгууллагад сургалт зохион байгуулах, зөвлөмж чиглэл хүргүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна.</p>	50
<p>Төсвийн төсөлд зөвхөн Төсвийн тухай хуулийн 29, 29<sup>1</sup> дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх.</p>	<p>МУЗГ-аас хэрэгжүүлж буй "Цахим үндэстэн" болох уриалгын хүрээнд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газраас "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг сайжруулах" шат дараалсан арга хэмжээний нэг нь PIMIS төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг систем нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, хяналт, тайлагналтын үйл ажиллагааг сайжруулах, олон улс дахь Монгол улсын үнэлгээг сайжруулах, Дэлхийн банкнаас гаргасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад заавал байх 8 элементийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын аливаа мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хүнээс хамаарсан техник ажиллагааг бууруулах үндсэн зорилготой юм. Мөн ТАХ-г төлөвлөхийн зэрэгцээ иргэд, олон нийт давхар хяналт тавих, санал өгөх боломжтой болсон. Түүнчлэн жил бүр ТЕЗ нар аймаг, нийслэлийн ЗД нарт УТХО-ын төлөвлөлтийн талаар жил бүр чиглэл хүргүүлдэг бөгөөд 2025 оны төлөвлөлтийн талаар 2024 оны 01/1273 тоот албан бичгээр 3 чиглэл бүхий мэдээллийг хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>2025 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний хувьд дараах шаардлагыг хангасан байх</li> <li>Төсвийн төлөвлөлтийн шинэчилсэн цаглабарыг мөрдөх</li> <li>Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах, ногоон болон эрчим хүчний хэмнэлттэй төслүүдийг нэмэгдүүлэх зорилтыг хангах чиглэлийн төслүүд төлөвлөх</li> </ol>	80



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>МУИХ-ын нэгдсэн чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад УТХО-аар хэрэгжүүлэх 3,384.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1,300 төсөл, арга хэмжээ батлагдсан. ТАХ-ний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу тус тус зохион байгуулах, "төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем-РИМИС"-ээр хэрэгжүүлэх талаар Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/8873 тоот албан бичгээр ТЕЗ нарт 3 бүлэг бүхий 24 хэсэгтэй чиглэлийг хүргүүлсэн.</p>	<p>100</p>
<b>Эдийн засаг, хөгжлийн яам</b>		
<p>Төсвийн төслийг тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эсэх хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, орон нутгийн хэмжээнд үр дүнтэй удирдан зохион байгуулах;</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3-т заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яам нь Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх чиг үүрэгтэй. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1788 дугаар албан бичгээр Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмын дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй "Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төсөлтэй хамтран "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулах зорилгоор "Үр дүнд суурилсан арга зүйгээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах нь" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд яам болон төрийн захиргааны 48 байгууллагын 300 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Монгол Улсын богино, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлал, зааврыг нэтрүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам"-д нийцүүлж баримт бичиг тус бүрийн онцлогийг тусган боловсруулж Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал", 2023 оны А/25 дугаар тушаалаар "Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал", 2023 оны А/26 дугаар тушаалаар "Аймаг, нийслэлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг тус тус батлуулж мөрдөн ажиллаж байна. Түүнчлэн "Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах аргачлал", "Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ын төслийг боловсруулсан.</p>	<p>50</p>
<p>Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хэлэлцээрт орж буй төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж санхүүжүүлэх журам арга, аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т заасны дагуу хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд журам, аргачлал зэрэг захиргааны хэм хэмжээний актыг эрх бүхий этгээд баталж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж бүртгүүлсний үндсэн дээр хүчин төгөлдөр хэрэгжих зохицуулалттай. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж, санхүүжүүлэх журам арга, аргачлал батлах асуудлыг хуулиар тусгайлан эрх олгож зохицуулаагүй байна.</p> <p>Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9-т "Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална." гэж заасан байх ба тус хуульд энэ чиглэлээр нэмэлт, өөрчлөлт ороогүй байна. Харин тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "энэ хуульд өөрөөр заагаагүй бол арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;" , 6.4.4-т "гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах;" гэж заасан зарчмуудыг баримтлан ажиллаж байна.</p> <p>Шинээр гадаадын зээл авч өр үүсгэхэд Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 буюу "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;" заалтыг баримталдаг. Өрийн удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл буюу "Засгийн газрын гадаад зээл, түүнд тавигдах шаардлага"-ыг мөрдөж ажиллах ба 23.2-т "Засгийн газрын арилжааны нөхцөлтэй гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5-т заасан шаардлагыг хангасан байна." гэж заасныг баримталдаг. Эдийн засаг, хөгжлийн яам нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн</p>	<p>50</p>



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

	<p>үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэгтэй. Энэ хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жагсаасан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” буюу төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг боловсруулж, УИХ-аар батлуулдаг.</p> <p>Тус яамнаас Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ын дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал, зааврыг боловсруулж, батлуулах ажлыг хийж байна. Үүний хүрээнд Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал, дагалдах гарын авлагуудыг боловсруулж, УХОХ-ийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.</p> <p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, Төр хувийн хэвшлийн түншлэл болон бусад эх үүсвэрээр санхүүжих төслүүд байх бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн төслийн саналыг ач холбогдол, хэрэгжих боломж гэсэн 2 ерөнхий шалгуураар үнэлж, эрэмбэлнэ. Дээрх ерөнхий шалгуурын хүрээнд санхүү, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг тогтоохдоо төслийн санхүү, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн тооцоо, судалгаанд үндэслэн төслийн санхүүжилтийн схем боловсруулагдаж, төслийн төсөвт өртөг, орлого, зарлага, санхүүгийн тооцоолол бодитой хийгдсэн эсэх, төслийн санхүүгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн нийтлэг үзүүлэлтүүд хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг хангасан эсэх (NPV, IRR, B/C) гэх мэт үзүүлэлтүүдэд үндэслэн санхүүжилтийн эх үүсвэр олгох эсэх шийдвэрийг тодорхойлно.</p> <p>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалын дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хавсралт болох Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслүүдийг үнэлж, эрэмбэлэн, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барьж, батална.</p>	
<b>Сангийн яам</b>		
<p>УИХ-аас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн төсвийн төслийг боловсруулж байх;</p>	<p>Жил бүрийн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 болон 7.4 дэх хэсэгт заасны дагуу төсвийн тусгай шаардлагыг хангаж, Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьдаг. Мөн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно.” гэж 7.5 дахь хэсгийг нэмсэн. Тус хуулийн дагуу Төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлах боломжгүй болсон.</p>	0
<p>Хөгжлийн бодлогод нийцүүлсэн, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг сайжруулах;</p>	<p>Сангийн яам үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн нэгдсэн арга зүйгээр хангах зорилгын хүрээнд 2023 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөлтэй хамтран бүх салбар яамд, 21 аймаг, нийслэл, дүүргийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан 1,895 төрийн албан хаагчдыг (733 эрэгтэй, 1162 эмэгтэй) хамруулсан нийт 32 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Үүнээс 165 нь удирдах түвшний албан хаагчид байсан байна.</p> <p>Уг ажлыг үргэлжлүүлэн 2024 оны 5 сарын байдлаар нийт 7 удаа, орон нутаг болон салбар яамдын төсөв, санхүү, бодлогын газрын холбогдох 835 төрийн албан хаагчдыг хамруулсан дараах сургалтуудыг зохион байгуулаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал, хяналт шинжилгээ” сургалт;</li> <li>- “Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайлагналын тушаал, системийн танилцуулга” сургалт;</li> <li>- “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-д салбарын үр дүнд суурилсан төсөвлөлт, тайлагналын танилцуулга, сургалт;</li> <li>- “Төлөвлөлт, төсөвлөлт, тайлагнал” сургалт;</li> <li>- “Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах нь” сургалт;</li> <li>- “Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт” сургалт;</li> <li>- “Үр дүнд суурилсан төсөвлөлт” сургалт.</li> </ul> <p>Мөн төслийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл, 2026 ба 2027 оны төсвийн төсөөллийг үр дүнд суурилсан арга зүйг баримтлан боловсруулах шинэчилсэн маягыг боловсруулан, тус маягын дагуу Боловсрол шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Байгаль орчин, Соёл урлаг, Биеийн тамир спорт,</p>	100



Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

	<p>Нийгмийн хамгаалал, Хөдөлмөр эрхлэлт, Хөдөө аж ахуй, Эрчим хүч, Зам тээвэр салбар болон Завхан, Дорноговь аймгуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p>	
<p>Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн, зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусган боловсруулж байх;</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглүүлэх, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр сангийн яамнаас дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:</p> <p>1. Хууль, эрх зүйн хүрээнд</p> <p>Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба тэдгээрийн үйл ажиллагаанд төсвийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төслийг тус яамнаас боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дагуу 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Тус хуулийн 13 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар зохицуулсан.</p> <p>Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын зохицуулалтуудад өөрчлөлт орсон. Тухайлбал тус хуулийн 291 дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэмж тусгасан бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлтийг сайжруулснаар төсвийн сахилга бат нэмэгдэн, хэрэгжилт сайжрах боломж, нөхцөлийг бий болгосон.</p> <p>Сангийн яамнаас Дэлхийн банк, Олон Улсын валютын сантай хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон. Уг хуулиар нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн.</p> <p>"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг шинэчлэн Засгийн газрын 278 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд төсвөөс санхүүжих бүх эх үүсвэрийн санхүүжилтийг нэгдсэн журмаар зохицуулах боломжтой болсон.</p> <p>Мөн Төсвийн тухай хуулийн 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан 11 дүгээр зүйлийн 11.1.23-т заасны дагуу "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал" Сангийн сайдын 137 дугаар тушаалаар батлагдсан. Уг аргачлалаар шинээр хэрэгжүүлэх төслүүдийг нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээг хийж эх үүсвэрийг эрэмбэлэх эрх зүйн орчин тус тус бүрдсэн.</p> <p>Мөн Төсвийн тухай хуулийн 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр шинэчлэгдэн батлагдсан төсвийн цаглабарын дагуу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэгдэн Сангийн сайдын А/264 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд төсвийн цаглабар болон төсвийн төлөвлөлтийн үе шатыг хуульд нийцүүлсэн.</p> <p>2. Цахим системийн шинэчлэлийн хүрээнд</p> <p>Төрийн үйл ажиллагааг оновчтой, түргэн шуурхай, ил тод, нээлттэй зохион байгуулах, үйлчилгээг сайжруулах зорилгын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ийг боловсруулан 2018 оноос үйл ажиллагаандаа ашиглаж ирсэн бөгөөд 2022 онд шинэчилсэн 3.0 хувилбарыг нэвтрүүлж, нээлттэй, ил тод, хэмнэлттэй байдлыг сайжруулан, хөрөнгө оруулалтын бүхий л үе шатыг бүрэн цахим, ил тод нээлттэй болголоо.</p> <p>Тухайлбал, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, эрх шилжүүлэлт, хуваарилалт, худалдан авах ажиллагаа, гэрээний удирдлага, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилтийг автоматжуулах, өмч бүртгэл, төслийг коджуулах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зэрэг олон үе шат, үйл ажиллагааг нэгдсэн цахим систем дээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог төсвийн хөрөнгө оруулалтай нэгтгэх, нэгдсэн тоо мэдээллийг харуулах дэд системийг хөгжүүлсэн бөгөөд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд уг системийг бүрэн ашиглан хэрэгжилтийг хангаж байна.</p>	<p>80</p>





Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн  
төсөлд өгсөн аудитын дүгнэлт

<p>Гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хэлэлцээрт орж буй төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж санхүүжүүлэх журам арга, аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	<p>Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.2 дахь заалтад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудал нь “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, зээл, тусламжийн нэгдсэн бодлого”, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2 дахь заалтад “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэж заасан байдаг. Иймд тус зөвлөмж нь эрхлэх асуудлын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яаманд хамааралтай байна. Сангийн яамны зүгээс Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх шаардлагыг тавьж ажиллаж байна. Мөн тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтад заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зорилго, нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, эргэн төлөгдөх чадвараас нь хамааруулж, төсөл хэрэгжүүлэх гэрээний үндсэн дээр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх эсвэл дамжуулан зээлдүүлэх байдлаар хэрэгжүүлж байгаа болно. Түүнчлэн, Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дахь хэсэгт “Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам”- ыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэж заасны дагуу тус журмын төслийг боловсруулан, Загийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p>	<p>80</p>
---	---	-----------